МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

СОЁЛЫН ЯАМ

# СОЁЛЫН ӨВИЙН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН 2022 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

**Соёлын өвийн үндэсний төвийн 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт**

| д/д | | Үзүүлэлтүүд | Төсөв (мян төг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хугацаа | Хариуцах нэгж | Хүрсэн түвшин (хэрэгжилт) | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 |
| **Нэг.Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилтын хүрээнд** | | | | | | | | | | |
| Зорилт 1. Соёлын салбарын мэдээллийн тогтолцоог бүрдүүлэх, соёлын бүтээлч үйлдвэрлэлийн мэдээллийг "Цахим соёл" арга хэмжээ, "GLAM" системтэй холбох, системийг ашиглалтад оруулахад соёлын өвийн бүртгэл, мэдээллээр хангаж ажиллана. (Соёлын яамны Стратеги төлөвлөгөө 2021-2024-ийн Стратегийн зорилт 2, 2.1 "Цахим соёл" арга хэмжээ) | | | | | | | | | | |
| 1 | 1.1 | "GLAM системийн нэгдсэн хөгжүүлэлт" нэгдсэн системд хөгжүүлэхэд хамтран оролцоно. | Байгууллагын төсөв | Систем хөгжүүлэлтийн бодлогын даалгавар боловсруулагдсан байдал<br><br>Хамрагдсан соёлын биет өвийн тоо. | Анх удаа | "GLAM" системд улс, аймгийн, музейн 50,000 хүртэлх үзмэрийн мэдээллийг хамруулсан байна. | I-IV | Соёлын өвийн бүртгэл, судалгааны газар<br><br>Мэдээллийн технологи, аюулгүй байдлын газар | Соёлын яамны Цахим бодлого, мэдээллийн технологийн хэлтэс болон бусад оролцогч талуудтай хамтарсан уулзалтыг 2 удаагийн хийж, GLAM системийн хэрэглэгчийн шаардлага тодорхойлох баримт бичигт орох соёлын өвийн бүртгэлд холбогдох тодорхой санал өгөв.<br>Улс, аймгийн музейн REGISTER программд бүртгэгдсэн 57688 дэсийн 120680 ширхэг үзмэр, эд өлгийн зүйлийн мэдээллийг цэгцлэн "GLAM" системд хөрвүүлэх бэлтгэл ажлыг хангаад байна.<br>Үр дүнд: Улсын 9, аймаг, орон нутгийн 24 музейн REGISTER программд бүртгэгдсэн үзмэр, эд өлгийн зүйл GLAM системд хөрвүүлэгдэх бэлтгэж ажил бүрэн хангагдсан. | 100 |
| Зорилт 1.2. Монгол бичгийг нийтийн болон албан хэргийн түвшинд хэрэглэж хэвшүүлэх ажлыг эхлүүлнэ.<br>(Соёлын яамны Стратеги төлөвлөгөө 2021-2024-ийн Стратегийн зорилт 4, 5.2 Монгол бичгийн үндэсний хөтөлбөр) | | | | | | | | | | |
| 2 | 1.2 | Байгууллагын ажилтан, албан хаагчдын Монгол бичгийн мэдлэгийн түвшинг дүгнэж, анхан болон түвшин ахиулж, монгол бичгээр уншиж, бичиж сурсан байна. | Байгууллагын төсөв | Зохион байгуулсан сургалтын тоо.<br>Анхан шатны сургалтад хамрагдсан ажилтны тоо.<br><br>Ахисан түвшний сургалтад хамрагдсан ажилтны тоо. | Анх удаа | Анхан шатны болон ахисан түвшний сургалт зохион байгуулсан байна. Ажилтнуудын 80 хүртэл хувийг хамруулна. | I-IV | Захиргаа, удирдлагын газар | Нийт ажилтнуудын Монгол бичгийн мэдлэгийн талаарх судалгааг авч судалсны үндсэн дээр Монгол бичгийн хичээлийн хөтөлбөр, удирдамж боловсруулж, Үндэсний төвийн захирлаар батлуулан 2 удаа сургалт зохион байгуулсан.<br>Эхний сургалт 2022.03.07-04.28-ны хооронд "анхан" болон "ахисан" түвшний шаталсан хэлбэрээр зохион байгуулагдсан ба "анхан" шатны сургалтын 9 цагийн хичээлд 18 ажилтан, "ахисан" түвшний 8 цагийн хичээлд 28 (давхардсан тоогоор) ажилтан хамрагдсан.<br>Соёлын сайдын 2022 оны А/116 дугаар тушаал батлагдсантай холбогдуулан байгууллагын ажилтны орон тоо 35 хүртэл хүнээр нэмэгдсэн ба шинээр ажилд орсон ажилтнуудаас Монгол бичгийн мэдлэг, чадвараа сайжруулах шаардлагатай 25 ажилтанг хамруулсан 2 дахь удаагийн "ахисан" түвшний 11 цагийн цагийн сургалт 2022.11.21-12.15-ны хооронд зохион байгуулагдаж байна.<br>Монгол хэл, бичгийн мэргэжлийн багшийн заасан Монгол бичгийн "анхан" шатны түвшний нийт 9 цагийн сургалтад 18 ажилтан, "ахисан" түвшний нийт 19 цагийн сургалтад 53 (давхардсан тоогоор) ажилтан тус тус хамрагдав. Хоёр удаа зохион байгуулсан дээрх сургалтад нийт ажилтнууд 100% хамрагдан Монгол бичгээр унших, бичих мэдлэгээ ахиулан амжилттай сайн суралцлаа.<br>Нийт 10 долоон хоног зохион байгуулагдсан сургалтын чанар, үр дүнг "цээж бичиг", "хуулан бичлэг", "уншлага" зэрэг хичээлээр дүгнэхэд ажилтнуудын Монгол бичгээр унших, бичих мэдлэг чадвар жигд дээшилсэн үр дүнтэй арга хэмжээ болсон.<br>Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого "Алсын хараа 2050"-ын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 1.3 дугаар зорилтыг хэрэгжилтийн бэлтгэл ажил хангаж Монгол бичгийг нийтийн болон албан хэргийн түвшинд хэрэглэж хэвшүүлэх ажлыг эхлүүлж ажилтнуудын дунд "сайхан монгол бичигтэн"-г шалгаруулах, албан нэрийн хуудас, байгууллагын албан өрөө тасалгааны хаягжилтыг хос бичгээр хийгээд байна. | 100 |
| **Зорилт 2 Хуулиар тусгайан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд** | | | | | | | | | | |
| **Зорилт 2.1. Төрийн байгууллага, аймгийн Соёлын газар, үндэсний, улсын, бүс нутгийн музей, судалгааны байгууллагатай хамтран улсын хэмжээнд соёлын өвийн бүртгэл, судалгаа, баримтжуулалтын ажлыг хамтран зохион байгуулна. (СӨХ тухай хуулийн 23.2)** | | | | | | | | | | |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 3 | 2.1.1 | Улсын хэмжээнд 2021-2022 онд шилжилт хөдөлгөөнд орсон соёлын өвийн тоон дүн, мэдээг салбарын хэмжээнд нэгтгэн, Соёлын яаманд тайлагнах ажлыг зохион байгуулна. | Байгууллагын төсөв | Соёлын өвийг хамгаалах хуулийн 23.2 дахь заалт хэрэгжсэн байна.<br><br>Шинээр нэмэгдсэн соёлын өвийн тоо.<br><br>Шилжилт, хөдөлгөөнд орсон соёлын өвийн тоо.<br><br>Хамрагдсан байгууллагын тоо. | Нэмэгдсэн музейн үзмэр 966 дэсийн 1422 ширхэг.<br><br>Нэмэгдсэн түүх, соёлын үл хөдлөх дурсгал 217 дурсгалт газрын 480 дурсгал.<br><br>Нэмэгдсэн соёлын биет бус өвийг өвлөн уламжлагч 632 | Улаанбаатар хот, 21 аймаг нийт 22 засаг захиргааны нэгж хамрагдана.<br><br>Үндэсний, улсын, бүс нутгийн болон орон нутгийн бүх музей, орон нутаг судлах танхим хамрагдана.<br><br>Улсын хэмжээнд нэмэгдсэн, шилжилт хөдөлгөөнд орсон, соёлын өвийн эсрэг гэмт хэрэгт өртсөн зэрэг тоон дүн нэгтгэгдэнэ. | I-IV | Соёлын өвийн бүртгэл, судалгааны газар<br><br>Мэдээллийн технологи, аюулгүй байдлын газар | Соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн сангийн 2021 оны тоон дүн, шилжилт хөдөлгөөний мэдээллийг энэ оны эхний улиралд нэгтгэв. 2021 оны тоон дүнгээр<br>-Түүх, соёлын үл хөдлөх 195 дурсгалт газрын 1127 дурсгал,<br>-Музейн сан хөмрөг (2,635,265,304 төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий) 1192 дэсийн 1829 ширхэг түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйл,<br>-Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагч 340 хүн шинээр тус тус бүртгэгдэв.<br>Монгол Улсын хэмжээнд 2022 оны байдлаар нийт 10843 дурсгалт газрын 90998 түүх, соёлын хөдлөх дурсгал, нийтийн өмчийн 317 байгууллагын 139714 дэсийн 329279 ширхэг (144,082,452,290 төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий) түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйл, соёлын биет бус 362 өвийн 11189 өвлөн уламжлагчийн бүртгэл СӨУНБМСанд хадгалагдаж байна. Улсын хэмжээний соёлын өвийн шилжилт хөдөлгөөн, хадгалалт хамгаалалт, ашиглалтын байдлын нэгдсэн судалгаа гарсан. Соёлын өвийн бүртгэл, мэдээллийн сангийн 2021 оны соёлын өвийн тоон дүн мэдээний тайланг Соёлын яам, холбогдох байгууллагад хүргүүлж, www.ncch.gov.mn цахим системд байршуулж олон нийтийг мэдээллээр хангаж байна.<br>Ажлын үр дүнд музей, аймаг, нийслэл болон улсын хэмжээний соёлын өвийн тоон статистик дүн мэдээний нэгтгэлийг бий болгосон. Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 23.2, 32.2.3 дахь заалт хэрэгжиж байна. | 100 |
| 4 | 2.1.2 | Төвийн болон Хангайн бүсийн 5 аймгийн Соёлын газартай хамтран соёлын өвийн УНБМСан дахь түүх, соёлын үл хөдлөх дурсгалын мэдээллийн санг бүртгэл судалгаа, гэрэл зураг, дүрс бичлэгээр баримтжуулж, баяжуулна. | Яамны нэмэлт санхүүжилт<br><br>9,740.0 | Мэдээллийн санг баяжуулсан гэрэл зураг, дүрс бичлэгийн хэмжээ, хэрэглэгдэхүүний тоон дүн.<br><br>Хамрагдсан аймаг, дурсгалын тоо.<br><br>Дурсгалын тухайн үеийн ашиглалт, хадгалалт хамгаалалт, орчин нөхцөл байдлыг | 2020-2021 онд Хэнтий, Дорнод, Сүхбаатар, Баянхонгор 4 аймгийн 121 дурсгалт газар хамрагдсан.<br>2021 онд 10.2ТВ цахим мэдээллээр ТСҮХД-ын мэдээллийн сан баяжигдсан.<br>2021 оны байдлаар Соёлын өвийн УНБМСан дахь ТСҮХД-ын цахим сангийн мэдээллийн хэмжээ 14ТВ | Төвийн болон Хангайн бүсийн 5 хүртэлх аймгийн нутагт орших 100 хүртэлх түүх, соёлын үл хөдлөх дурсгал хамрагдсан байна.<br><br>Соёлын өвийн УНБМСан дахь ТСҮХД-ын цахим сангийн мэдээллийг 20ТВ хүртэл хүргэж нэмэгдсэн байна. | I-IV | Соёлын өвийн бүртгэл, судалгааны газар<br><br>Мэдээллийн технологи, аюулгүй байдлын газар | Тухайн арга хэмжээг зохион байгуулах санхүүжилт шийдэгдээгүйн улмаас төлөвлөгөөнд тусгагдсан 5 аймгаас Дундговь, Дорноговь, Увс аймгийн түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг гэрэл зураг, дүрс бичлэгээр баримтжуулах ажлыг "Монголын баялаг, өв соёл" ХХК-тай хамтран хэрэгжүүлж буй "Монголын баялаг 330" төсөлтэй уялдуулан зохион байгуулав. Баримтжуулалтад дээрх 3 аймгийн нутагт орших "улсын хамгаалалтад түүх, соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалт"-д батлагдсан 17 дурсгалт газар, "аймгийн хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалт"-д батлагдсан 59, хамгаалалтын зэрэглэлд ороогүй нийт 124 дурсгалт газар хүртэлх дурсгалт газар хамрагдсан. Ажлын үр дүнд дүрс бичлэг, гэрэл зургийн 10 ТВ цахим файлаар СӨУНБМСан баяжигдсан, тайлант хугацаанд Дорноговь аймгийн нутаг дэвсгэр орших түүх, соёлын 49 дурсгал мэргэжлийн тайлбар, дүрс бүхий контент хэлбэрээр олон нийтэд хүрч, сурталчлагдав. Цаашид үе шаттайгаар баримтжуулалтад хамрагдсан бусад дурсгалын контент олон нийтэд хүрнэ. | 100 |
| 5 | 2.1.3 | Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалт газрын байршлын орон зайн мэдээллийг аймгийн Соёлын газартай хамтран газар зүйн мэдээллийн системд оруулан улсын тусгай хэрэгцээний ангилалд оруулах бэлтгэл ажлыг хийж, Соёлын яаманд хүргүүлсэн байна. | Байгууллагын төсөв | Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 25.1 дэх заалт хэрэгжих эхлэл тавигдана.<br><br>Хамрагдсан аймаг, түүх, соёлын үл хөдлөх дурсгалт газрын тоо.<br><br>Соёлын өвийн УНБМСанд төрөлжсөн товьёг үүссэн байх | Анх удаа | Улсын хамгаалалтад байх 197 хүртэлх дурсгалт газрын улсын тусгай хэрэгцээ буюу кадастрын бүртгэлд бүртгэх байршлын мэдээлэлд техник ажиллагаа хийгдсэн байна.<br><br>Соёлын өвийн УНБМСанд төрөлжсөн товьёг үүссэн байна. | I-III | Соёлын өвийн бүртгэл, судалгааны газар<br><br>Соёлын өвийг авран хамгаалах газар | Засгийн газрын 2020 оны 13 дугаар, 2021 оны 179 дүгээр тогтоолоор тус тус батлагдсан Улсын хамгаалалтад байх 197 түүх, соёлын үл хөдлөх дурсгалын байршлын 213 орон зайн мэдээллийг зайнаас тандах аргаар газарзүйн байршил, хамрах хүрээний солбицол, талбайн хэмжээ тус бүрийг тодорхойлж, мэдээллээ аймаг, нийслэлийн Соёл урлагийн газруудад 2022 оны 3 дугаар сард 01/120 дугаар албан бичгээр хүргүүлсэн.<br>2022 оны 6 дугаар сарын байдлаар 17 аймаг дээрх албан бичгийн хариуг ирүүлснийг нэгтгэж, шалган зурагласны дүнд газарзүйн мэдээллийн систем (ГМС)-д орон зайн хүснэгтэн мэдээллийг байгуулж, мэдээллийн сан үүсгээд байна. Ажлын үр дүнд:<br>-Улсын хамгаалалтад байх үл хөдлөх дурсгалын орон зайн мэдээллийг орон нутгийн газрын мэдээллийн сантай хамтран дундын мэдээллийн сан үүсгэснээр хамрах хүрээ болон хамгаалалтын бүсийн нэгдсэн мэдээлэлтэй болох;<br>Улсын хамгаалалтад байх 213 дурсгалын орон зайн мэдээллийг Газар зохион байгуулалт, геодизи зураг зүйн газартай хамтран 1/337 албан тоот бичгээр мэдээлэл солилцож тус газраас ирүүлсэн газрын харилцааны мэдээлэлтэй давхардаж байгаа 63 дурсгалт газрын 8 дурсгалт газрын орон зайн мэдээллийн өөрчлөн зураглаж 6 дурсгалт газрын орон зайн мэдээллийн газрын кадастрын хилээр засаж оруулав. Үл хөдлөх 29 дурсгалт газрын хамрах хүрээ өвөлжөө, хаваржааны газар олголттой давхацсан, 13 дурсгалт газрынх жуулчны бааз, ашигт малтмалын хайгуулын талбай, холбооны шугам, музейн газар олголт зэрэгтэй давхцаж байна.<br>Байгаль орчин, аялал жуулчны яамтай хамтарч улсын тусгай хамгаалалттай газартай газарт орсон болон хил зааг давхардаж байгаа 46 дурсгалт газрын орон зайн мэдээллийг 1/389 албан тоот бичгээр хүргүүлж мэдээллийн санд бүртгүүлэх ажлыг хийж байна.<br>Эхний байдлаар Засгийн газрын тогтоолоор баталсан хамгаалалтын бүстэй 12 дурсгалт газрын орон зайн мэдээлэл Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 45.1, Газрын тухай хуулийн 16.1.15 заалтын хэрэгжилтийг хангаж байна. | 100 |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 6 | 2.1.4 | Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийг өмчлөгч, эзэмшигч байгууллагатай хамтран бүртгэл судалгаа, гэрэл зураг, дүрс бичлэгээр баримтжуулж, соёлын өвийн УНБМСан дахь түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн мэдээллийн санг баяжуулна. | Байгууллагын төсөв | Мэдээллийн санг баяжуулсан гэрэл зураг, дүрс бичлэгийн хэмжээ.<br><br>Хамрагдсан байгууллага, дурсгалын тоо.<br><br>Дурсгалын тухайн үеийн ашиглалт, хадгалалт хамгаалалт, орчин нөхцөл байдлыг баримтжуулсан байдал. | 2021 онд<br>Түүх, угсаатны зүй хүрээлэн (Археологи)-ийн 1.20 цагийн 14 GB, Үндэсний номын сангийн 20 дэсийн 456 ширхэг дурсгалын 11.30 цагийн 76 GB,<br>2021 онд 90GB цахим мэдээллээр ТСХДЗ-ийн хосгүй үнэт дурсгалт зүйлийн мэдээллийн сан баяжигдсан.<br>2021 оны байдлаар Соёлын өвийн УНБМСан дахь ТСҮХД-ын хосгүй үнэт дурсгалт зүйлийн цахим сангийн мэдээллийн хэмжээ 3.5 ТВ байна. | Түүх, соёлын хосгүй үнэт 30 хүртэлх дурсгалт зүйлийг гэрэл зураг, дүрс бичлэгээр баримтжуулсан байна.<br><br>Баримтат өвийн жагсаалтад хамаатах түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн бүртгэл, жагсаалттай болсон байна.<br><br>Соёлын өвийн УНБМСан дахь ТСҮХД-ын цахим сангийн мэдээлэл 5 ТВ хүртэлх хувиар нэмсэн байна. | I-III | Соёлын өвийн бүртгэл, судалгааны газар<br><br>Соёлын өвийг авран хамгаалах газар | 2022 онд нийт түүх, соёлын 21 хосгүй үнэт дурсгалт зүйлийг гэрэл зураг, дүрс бичлэг, 3D, дижитал баримтжуулалт, 17 төрөл зүйлийн 12418 ширхэг баримтат өвийн төрөлжсөн бүртгэлээр соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн сан баяжигдав. Үүнд:<br>- Өвөрхангай аймгийн Хархорин сумын нутагт орших Шанхын Баруун Хүрээ хийдэд хадгалагдаж буй түүх, соёлын хосгүй үнэт зэрэглэлд батлагдсан 19 дурсгалт зүйлийг гэрэл зураг, дүрс бичлэгээр баримтжуулах ажлыг зохион байгууллаа. Ажлын үр дүнд 26.15 GB хэмжээтэй 1132 кадр гэрэл зураг, 115 GB хэмжээтэй 3 цаг 17 минут 33 секундын дүрс бичлэгийн файлыг СӨУНБМСанд товьёгжуулж хадгалав. Хосгүй үнэт дурсгалт зүйлсийг баримтжуулах ажлын явцад дурсгалын нэр, материал, хэмжээ, хувийн дугаар зэрэг өгөгдөл мэдээллийг "Музейн үзмэр, эд өлгийн зүйлийн ерөнхий бүртгэл" болон Засгийн газрын тогтоолтой тулган тус тогтоолд "дурсгалын нэр" зөрүүтэй, "хэмжээ" дутуу, эзэмшигч ташаарч бичигдсэнийг олж тогтоон тэмдэглэв.<br>- Засгийн газрын 2022 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн хуралдааны 24 дүгээр тэмдэглэлд тусгагдсан үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх хүрээнд Монголын Бурханы шашинтны Төв Гандантэгчэнлин хийдтэй хамтран ажиллах санамж бичиг байгуулан, хуралдааны тэмдэглэлд заасан ажлуудыг төлөвлөгөө гарган гүйцэтгэж байна. Төлөвлөсний дагуу 2022 оны 11 дүгээр сард тус хийдэд хадгалагдаж буй түүх, соёлын хосгүй үнэт зэрэглэлийн "Бурхан багш", "Жүжигшал Жанрайсиг" 2 дурсгалт зүйл бурхан шүтээнийг 3D дижитал хэлбэрээр баримтжуулан 12 GB цахим сан Соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл,мэдээллийн санд хадгалав.<br>-Баримтат өвийн бүртгэл, мэдээллийн сан бүрдүүлэх, Үндэсний баримтат өвийн урьдчилсан жагсаалт бүрдүүлэх ажлын хүрээнд Монгол Улсын хэмжээнд нийт 17 төрөл зүйлийн 12418 ширхэг баримтат өв бүртгэлээ. Үүнд: Музей, номын сан-21, сүм хийд-26, сум-52, хувь хүн-446 хамрагдав. Баримтат өвийн судалгааг төрөл зүйлээр ангилж мэдээ тайланг нэгтгэн, СӨУНБМСанд хадгалав. | 100 |
| 7 | 2.1.5 | Соёлын биет бус өвийн гар урлал, уламжлалт технологи, байгалийн болон сав шим ертөнцийн тухай мэдлэг зан үйл, мал маллах арга ухааны төрлөөр соёлын өвийн УНБМСангийн соёлын биет бус өвийн мэдээллийн цахим санг бүртгэл судалгаа, гэрэл зураг, дүрс бичлэгээр баяжуулна. | Байгууллагын төсөв | Мэдээллийн санг баяжуулсан гэрэл зураг, дүрс бичлэгийн хэмжээ.<br><br>Хамрагдсан аймаг, хүний тоо.<br><br>Дурсгалын тухайн үеийн ашиглалт, хадгалалт хамгаалалт, орчин нөхцөл байдлыг | 2021 онд<br>-Өвөрхангай аймгийн 3 суманд 5 өвийн 28.6 GB,<br>-Архангай аймгийн 2 суманд 6 өвийн 48.3 GB, нийт 76.9 GB хэмжээтэй баримтжуулалт хийж соёлын биет бус өвийн мэдээллийн сан баяжигдсан.<br>2021 оны байдлаар Соёлын өвийн УНБМСан дахь СББӨ-ийн 1500 | Төвийн болон хангайн бүс дэх соёлын биет бус өвийн гар урлалын төрлөөр 5 хүртэл, уламжлалт технологийн төрлөөр 5 хүртэл, мал маллах арга ухааны төрлөөр 5, байгалийн болон сав шим ертөнцийн тухай мэдлэг зан үйлийн төрлөөр 5 нийт 20 хүртэлх өвийн мэдээллийн санг гэрэл | I-III | Соёлын өвийн бүртгэл, судалгааны газар | Төвийн болон хангайн бүсийн 4 аймагт соёлын биет бус өвийн баримтжуулалтын ажлыг зохион байгуулав. Дээрх ажлын хүрээнд төвийн болон хангайн бүсийн Дархан-Уул, Сэлэнгэ, Өвөрхангай, Төв аймгийн нийт соёлын биет бус өвийн 4 ай савын 23 төрөл зүйлд хамаарах 45 өвлөн уламжлагчийг бүртгэж, нийт 2691 ширхэг гэрэл зураг, 1341.092 GB дүрс бичлэгээр баримтжуулав. Үр дүнд: Уламжлалт арга ухааны төрөлд 9, гар урлалын төрөлд 31 хүн, мал маллах арга ухааны төрөлд 4, байгалийн болон сав шим ертөнцийн тухай мэдлэг зан үйлийн төрөлд 1, нийт 45 өвлөн уламжлагчийг баримтжуулж, 2691 кадр гэрэл зураг, 1341.092 GB дүрс бичлэг бүхий цахим файл СӨУНБМСанд хадгалагдав. | 100 |
| 8 | 2.1.6 | Түүх, соёлын дурсгалт газрыг Дэлхийн өвд бүртгүүлэхэд ЮНЕСКО-ийн МҮК, судалгааны байгууллагатай хамтран ажиллана. | Яамны нэмэлт санхүүжилт<br><br>11,443.0 | "Буган чулуун хөшөө" дурсгалыг Дэлхийн өвд бүртгүүлсэн байдал.<br><br>"Говийн хадны зураг" соёлын өвийн хээрийн бүртгэл, судалгаа хийгдсэн байдал.<br><br>Техникийн баримт бичгийг бүрдүүлж эхэлсэн байна. | 2020 онд Дэлхийн өвийн хороонд "Буган чулуун хөшөө" баримт бичиг илгээсэн.<br><br>"Говийн хадны зураг" соёлын өвийн хээрийн бүртгэл анх удаа | Дэлхийн өвийн жагсаалтад "Буган чулуун хөшөө"-соёлын өвийг нэр дэвшүүлж, баримт бичгийг илгээсэн байна.<br><br>"Говийн хадны зураг" соёлын өвийн хээрийн судалгаа хийж эхэлсэн байна. | II-IV | Соёлын өвийн бүртгэл, судалгааны газар<br><br>Соёлын өвийг авран хамгаалах газар | Монгол Улсаас Дэлхийн өвийн жагсаалтад Соёлын ангиллаар бүртгүүлэхээр бэлтгэж байгаа "Говийн хадны зураг", "Буган чулуун хөшөө" бүхий газруудад эрсдэлийн нөхцөл байдлын шинжилгээг газар дээр нь маягтын дагуу хийх, шаардлгатай бүртгэн баримтжуулах, сэргээн засварлах ажлыг хийж гүйцэтгэх хээрийн судалгааг 2022 оны 9 дүгээр сард зохион байгуулав.<br>Хээрийн судалгаагаар Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутагт орших Жавхлант хайрхан уулын хадны зураг, Баянхонгор аймгийн Баянлиг сумын нутагт орших Бичигтийн хадны зураг, Архангай аймгийн Ихтамир сумын Хойд Тамирын буган хөшөөд, Алтан сандал уулын буган хөшөөний цогцолбор газруудад тус Үндэсний төвөөс боловсруулсан эрсдэлийн маягтын дагуу нөхцөл байдлын шинжилгээ хийж, гэрэл зураг (7.45 GB ) болон видео бичлэг (35 GB), (гол хадны зураг төвлөрсөн хэсгийг) 3 хэмжээст загвараар бүртгэн баримтжуулалт хийв.<br>Энэхүү буган чулууны эрсдэл нөхцөл байдлын шинжилгээ сэргээн засварлах ажлын хүрээнд Хөвсгөл аймгийн Бүрэнтогтох сумын Уушигийн өврийн 9 дүгээр буган чулуун хөшөөнд сэргээн засварлалт хийсэн. (Сэргээн засварлалт хийсэн тухай тайлангийн 2.3.3-д бий.)<br>Хээрийн судалгааны ажлын тайлан болон файлыг нэгтгэн Соёлын өвийн Улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн санд шилжүүлэн хадгалав. | 100 |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 9 | 2.1.7 | ЮНЕСКО-ийн Соёлын биет бус өвийн жагсаалтад 3 өвийг нэр дэвшүүлэхэд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, хамтран ажиллана. | Байгууллагын төсөв | ЮНЕСКО-д "Наурыз" өвийн баримт бичгийг илгээсэн байдал.<br><br>Монгол уламжлалт анагаах ухаан", "Монгол нүүдлийн зан үйл" өвийн баримт бичгийг бүрдүүлж эхэлсэн байдал. | Анх удаа | ЮНЕСКО-ийн соёлын биет бус өвийн Төлөөллийн жагсаалтад "Наурыз" өвийг нэр дэвшүүлэхэд холбогдох бэлтгэлийг хангасан байна.<br>"Монгол уламжлалт анагаах ухаан", "Монгол нүүдлийн зан үйл" өв тус бүрийг нэр дэвшүүлэх баримт бичгийг боловсруулж эхэлнэ | I-II | Соёлын өвийн бүртгэл, судалгааны газар<br><br>Мэдээллийн технологи, аюулгүй байдлын газар | ЮНЕСКО-гийн Соёлын биет бус өвийн жагсаалтад нэр дэвшүүлэх 3 өвийн судалгаа, баримт бичгийн боловсруулалтад хамтран ажиллав. Үүнд:<br>- Казак түмний "Наурыз баяр" өвийн судалгаа, бүртгэн баримтжуулалтын хүрээнд Баян-Өлгий аймагт ажиллаж, судалгааны тайлан баримт бичгийг боловсруулах, ЮНЕСКО-гийн Үндэсний комисст илгээх, өвийн зүйлийг ЮНЕСКО-гийн Соёлын биет бус өвийг хамгаалах тухай 2003 оны конвенцийн Нарийн бичгийн дарга нарын газарт хүргүүлэх ажлыг гүйцэтгэв. Тайланг Монгол болон Англи хэл дээр тус төвийн албан ёсны веб сайтд байрлуулав. Линк: http://ncch.gov.mn/ich?ItemID=8<br>- Монгол Улсын соёлын биет бус өвийн Төлөөллийн үндэсний бүртгэлийн "Уламжлалт арга ухаан" ай савд хамаарах "Монгол уламжлалт анагаах ухаан", "Монгол нүүдлийн зан үйл" өвийг ЮНЕСКО-гийн СББӨ-ийн холбогдох жагсаалтад нэр дэвшүүлэх, судалгаа, баримт бичгийг бүрдүүлэх ажлын хүрээнд тус өвийг өвлөн уламжлагчийг бүртгэх, гэрэл зураг, дүрс бичлэгээр баримтжуулах хээрийн судалгааны ажлыг IV улиралд хийж гүйцэтгэв. Үүнд: Баянхонгор аймгийн Бууцагаан, Говь-Алтайн Алтай аймгийн Шарга, Ховд аймгийн Жаргалан, Дарви, Манхан, Баян-Өлгий аймгийн Өлгий, Буянт Сагсай зэрэг 8 сумыг хамруулж нийт 2 өвийн 18 өвлөн уламжлагчийн 931GB гэрэл зураг, дүрс бичлэгээр баримтжуулсан.<br>Үр дүнд: "Наурыз баяр" өвийн судалгааны тайлан баримт бичиг боловсруулагдаж хүргэгдсэн, "Монгол уламжлалт анагаах ухаан" өвийг нэр дэвшүүлэх, баримт бичиг боловсруулах судалгаанд ашиглагдах анхан шатны хэрэглэгдэхүүний бүрдэл хангагдсан. | 100 |
| 10 | 2.1.8 | Соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл мэдээллийн системийн техникийн даалгавар боловсруулж, систем хөгжүүлэлт хийхэд хамтран ажиллана. | Яамны нэмэлт санхүүжилт<br><br>35,000.0 | Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн бүртгэлийн программд нэмэлт хийгдсэн хөгжүүлэлтийн тоо. | Register программ 32 талбартай,<br><br>RCH программ 41 талбартай | Register болон RCH программд актлагдсан, дутсан, солигдсон, бичилтийн тэмдэгт нэмсэн, зураг нэмэх, бүртгэл хөтлөх, хайлтыг боловсронгуй болгох зэрэг 10 хүртэлх талбар нэмэгдэнэ | I-II | Соёлын өвийн бүртгэл, судалгааны газар<br><br>Мэдээллийн технологи, аюулгүй байдлын газар | Register болон RCH программуудад хийхээр төлөвлөсөн нэмэлт хөгжүүлэлт нь Соёлын яамнаас хийж буй "Соёлын өвийн бүртгэлийн нэгдсэн цахим систем"-тэй цаашид уялдах тул тус яамны Мэдээллийн технологийн хэлтсээс дээрх программуудын нэмэлт хөгжүүлэлтэд санхүүгийн зардал гаргахгүй байхыг чиглэл болгосон.<br>"Соёлын өвийн бүртгэлийн нэгдсэн цахим систем"-ийн техникийн даалгавар буюу бүрэн хэмжээний хэрэглэгчийн шаардлага тодорхойлолт бүхий баримт бичгийг Соёлын яамны Мэдээллийн технологийн хэлтэстэй хамтран 2022 оны 5 дугаар сарын 26-29-ний өдрүүдэд боловсруулав. "СӨБНЦС" цахим систем нь дотроо түүх, соёлын үл хөдлөх дурсгалын, түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн, соёлын биет бус өв, өвлөн уламжлагчийн, баримтат өвийн мэдээллийн дэд сангууд болон бүртгэлийн, статистик, тайлангийн, хайлт, шүүлтийн, гуравдагч байгууллагад зориулсан лавлагаа мэдээллийн, хувь хүнд зориулсан үйлчилгээний, орон зайн мэдээллийн, гэрэл зурагтай ажиллах, мэдэгдлийн, удирдлага, хяналтын (актлагдсан, дутсан, солигдсон г.м), хаяг тэмдэг бүртгэлийн, хэвлэх, экспортлох дэд системийн бүртгэлтэй байхаар төлөвлөв. Баримт бичгийг үндэслэн төрийн худалдан авах ажиллагааны тендер шалгаруулалт явагдах бөгөөд шалгарсан технологийн компанийн хөгжүүлэлтийн ажил дуусахад цахим систем хэрэглээнд нэвтрэхэд бэлэн болох юм. Энэхүү ажил хэрэгжсэнээр соёлын өвийн мэдээллийн чанар, хүртээмж сайжрах, соёлын өвийн бүртгэл, судалгаа, хадгалалт хамгаалалт, хяналт, ашиглалтын нэгдсэн тогтолцоог боловсронгуй болгох, салбарын бодлого шийдвэр үр нөлөөгөө өгөх, иргэдэд төрийн үйлчилгээ, соёлын өвийн мэдээ мэдээлэл түргэн шуурхай хүрэх зэрэг олон давуу талууд бий болно. | 100 |
| Зорилт 2.2. Соёлын өвийн хадгалалт хамгаалалтын орчныг сайжруулах, стратеги боловсруулах зорилгоор шинжлэх ухааны судалгааны байгууллага, үндэсний, улсын, бүс нутгийн музейтэй хамтран соёлын биет болон биет бус өвийн хадгалалт хамгаалалт, эвдрэл гэмтэл, хүрээлэн буй орчин болон материалын төрөлжсөн судалгаа хийнэ.<br>(СӨХ тухай хуулийн 20.3 дугаар заалт) | | | | | | | | | | |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 11 | 2.2.1 | Эзэмшигчийн хүсэлтээр соёлын биет өвд бүтэц, орц найрлагын судалгаа хийж, үзмэрийн бүртгэл тодорхойлолтыг нэмэлт мэдээллээр хангаж, сэргээн засварлалтын өмнөх оношлох судалгаанд ашиглана. | Яамны нэмэлт санхүүжилт<br><br>6,850.0 | Судалгаа хийгдсэн соёлын биет өвийн тоо.<br><br>Хамрагдсан музей, байгууллагын тоо. | 2021 онд 12 байгууллагын 152 үзмэрт материалын судалгаа хийгдсэн. | Материалын судалгааг 8 хүртэлх байгууллагын 100 хүртэлх үзмэрт хийж, үр дүнг эзэмшигч байгууллагад мэдэгдэнэ. | I-IV | Соёлын биет өвийг сэргээн засварлах газар | Материалын судалгааг нийт 9 байгууллага, 1 иргэний нийт 328 үзмэр үзмэр, дээжид өнгө будаг, металл, минерал будгийн орц найрлагад шинжилгээ хийсэн. Үүнд: ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн 46 ширхэг, Монголын Үндэсний музейн 20 ширхэг, Улаанбаатар их сургуулийн 26 ширхэг, Үндэсний төв архивын 25 ширхэг, Чингис хаан музейн 43 ширхэг, Хархорум музейн 6 ширхэг үзмэрт элементийн тодорхойлолт хийж, дурсгалт уран барилгын өнгө будгийн бүтэц найрлага тогтоох болон цавуулаг тогтоох судалгааг Богд хааны ордон музейн 80 ширхэг дээжид, Чойжин ламын сүм музейн 32 дээжид тус тус хийж уламжлалт материалын орц найрлага, өнгө будгийн төрөл зүйлийг тодорхойлж хадгалалт хамгаалалт, сэргээн засварлалт хийх арга зүйг боловсруулж, дээрх байгууллагуудад хүлээлгэн өгсөн. Эрүүгийн Цагдаагийн газраас ирүүлсэн 36 ширхэг дээж, 1 иргэний хүсэлтээр 10 ширхэг дээж, мөн Археологийн хүрээлэнгийн 4 ширхэг дээжинд SRF-ээр найрлага тодорхойлох шинжилгээ хийж, үр дүн боловсруулсан.<br>Материалын судалгааны ажлыг тогтмолжуулсанаар дурсгалын хадгалалт хамгаалалтын орчиныг сайжруулах, сэргээн засварлалтыг чанартай, үр дүн сайтай хийх үндэслэл бүрдэж байна. Иймээс цаашид материалын гистологи бүтэц, үүсэл гарвал, он цаг тогтоох шинжилгээ судалгааны лабораторитой болох шаардлагатай байна. | 100 |
| 12 | 2.2.2 | Музейн гал түймрийн гамшиг эрсдэлийн үнэлгээний судалгаа хийж, эрсдэлийн менежментийн загвар боловсруулж, музейд танилцуулна. | Байгууллагын төсөв | Судалгаа хийгдсэн музейн тоо.<br><br>Загвар бэлэн болсон байдал.<br><br>Музейд танилцуулсан байдал. | Анх удаа | Судалгаанд 8 хүртэлх байгууллага хамрагдсан байна. | I-IV | Соёлын өвийг авран хамгаалах газар<br><br>Соёлын биет өвийг сэргээн засварлах газар | Музейн гал түймрийн гамшиг эрсдэлийн нөхцөл байдлын судалгаа хийх, эрсдэлийн менежментийн загвар боловсруулахад 2022 оны 02 сарын 17-ний 01/71 тоот албан бичгээр Онцгой байдлын ерөнхий газарт хандаж арга зүйн зөвлөгөө авсан бөгөөд Монголын Үндэсний музей, Г.Занабазарын нэрэмжит Дүрслэх урлагийн музей, Чойжин ламын музей, Хархорум музей, Баян-Өлгий, Баянхонгор, Сүхбаатар, Ховд аймгийн музей зэрэг нийт 8-н музейгээс үндсэн 4 агуулга бүхий 28 асуулгаар нөхцөл байдал тодорхойлох судалгааг авч нэгтгэв.<br>Дээрх судалгааны нэгтгэлд тулгуурлан музейд гал түймрийн эрсдэл үүсгэх хүчин зүйлсийг үнэлж, эрэмбэлэн, эрсдэлийг бууруулах төлөвлөгөөг боловсруулан ажиллаж байна.<br>Монголын музейн салбарт гал түймрийн эрсдэлийн нөхцөл байдлын судалгааг улс, аймгийн музейн түвшинд анх удаа хийж байгаа бөгөөд нөхцөл байдлын үнэлгээний үр дүнд энэ төрлийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх менежментийн төлөвлөгөөний загварыг боловсруулж, музейн удирдлага цаашид мөрдөх, үйл ажиллагаандаа төлөвлөх боломжийг бүрдүүлэх ач холбогдолтой юм.<br>Ингэснээрээ музейн барилгад гал түймрийн эрсдэл учруулах хүчин зүйлсийг олж илрүүлэх, эрсдэлийг эрэмбэлэн Онцгой байдлын Ерөнхий газрын холбогдох төлөөлөлтэй соёлын өвийн эрсдэлийн чиглэлээр хамтран ажиллах эхлэл тавигдах боломж бүрдсэн. | 100 |
| 13 | 2.2.3 | Сүм хийд, дурсгалт барилгын сэргээн засварлалтын нөхцөл байдалд чанарын судалгаа хийж, Соёлын яаманд танилцуулна | Яамны нэмэлт санхүүжилт<br><br>5,565.0 | Судалгаа хийгдсэн дурсгалт газрын тоо. | Анх удаа | Судалгаанд 3 хүртэлх объект хамрагдсан байна.<br><br>Чанарын судалгаа хийгдсэн байна. | I-IV | Соёлын өвийг авран хамгаалах газар<br><br>Соёлын биет өвийг сэргээн засварлах газар | Сүм хийд, дурсгалт барилгын сэргээн засварлалтын нөхцөл байдалд чанарын судалгаа хийж, Соёлын яаманд танилцуулах ажлын хүрээнд 3 хүртэлх объектийг судалгаанд хамруулж, чанарын судалгаа хийх зорилт тавьсан. Энэхүү судалгаанд 2 аймаг, 3 сумын нийт 3 объектын нөхцөл байдалд чанарын судалгаа хийж тайлагнасан. Үүнд:<br>-Өвөрхангай аймгийн Бат-Өлзийт сумын нутагт байрладаг Төвхөн хийдийн агаарын тандалт судалгаагаар ургамлын индекс тодорхойлсон.<br>-Говьсүмбэр аймгийн Шивээговь сумын 2-р багийн нутагт байдаг Чойрын Богд ууланд бүтээгдсэн, Улсын хамгаалалттай соёлын өвд бүртгэлтэй Дагвасүндэл бурхны дурсгалыг будаж, бохирдуулсан тухай мэдээлэл авч, орон нутагт нь очиж ажиллан шинжээчийн дүгнэлт гаргаж, цэвэрлэн сэргээсэн.<br>-Өвөрхангай аймгийн Хархорин сумын нутаг дахь ЭрдэнэЗуу хийд байрлаж буй талбайн ургамлын индексийг мулти спектор камер ашиглан RTK системд суурилсан агаарын тандалт судалгаагаар тодорхойлсон.<br>Эдгээр судалгааны үр дүнд органик болон органик бус үл хөдлөх дурсгалын хүрээлэн буй орчны эрсдэлийн нөлөөлөл, хүчин зүйлийг тодорхойлон ангилах, гэмтлийн шалтгааныг тодорхой болгож мэдээллийн сан бүрдүүлэх, хадгалалт хамгаалалт, сэргээн засварлалт хийх аргазүй боловсруулан нутагшуулах үндсэн мэдээллийн сан болгож ашиглах, харьцуулсан судалгаа хийх суурь судалгааны эхлэлийг тавьсан. | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 14 | 2.2.4 | Судалгааны байгууллагатай хамтран бүс нутгийн хэмжээнд угсаатны бүлгийн соёлын биет бус өвийн оршин тогтнох чадавхад тандалт судалгаа хийж, үр дүнг Соёлын яаманд танилцуулна. | Байгууллагын төсөв | Хамрагдсан аймгийн тоо.<br><br>Хамрагдсан угсаатны бүлэг, тоо.<br><br>Хамрагдсан соёлын биет бус өв, өвлөн уламжлагчийн тоо.<br><br>Цуглуулсан гэрэл зураг, дүрс бичлэг хэрэглэгдэхүүний тоон дүн | Анх удаа | Хангайн болон төвийн бүсийн соёлын биет бус өв, өвлөн уламжлагчид хамрагдсан байна.<br><br>Чадавхыг үнэлсэн байна.<br><br>Соёлын биет бус өвийн үндэсний экспедицийн судалгаанд хамтран оролцсон байна. | I-III | Соёлын өвийн бүртгэл, судалгааны газар<br><br>Мэдээллийн технологи, аюулгүй байдлын газар | Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Соёл, урлагийн газрын даргын 2022 оны А/42 дугаар тушаалын дагуу "Соёлын биет бус өвийн үзлэг, бүсчилсэн судалгаа"-г Соёлын өвийн үндэсний төв, Шинжлэх ухааны академийн Түүх, угсаатны зүйн хүрээлэн, Нүүдлийн соёл, иргэншлийг судлах олон улсын хүрээлэнтэй хамтран IV улиралд зүүн бүсийн 3 аймаг, Улаанбаатар хотыг хамруулан зохион байгуулав. "Соёлын биет бус өвийн үзлэг, бүсчилсэн судалгаа"-ны зорилго нь СББӨ-ийг сурвалжлан олох, судалгаа шинжилгээ хийх, хадгалалт хамгаалалтын нөхцөл байдал, зэрэг болон сөргөөр нөлөөлж буй хүчин зүйлсийг судлах, тархалтыг тогтоох, үзлэгийн мөрөөр авах арга хэмжээний санал боловсруулах, шаардлагатай хэрэглэгдэхүүн, мэдээлэл цуглуулах юм. Судалгаанд Дорнод, Хэнтий, Сүхбаатар болон Улаанбаатар хотын 9 дүүрэг хамрагдав. Судалгааны үр дүнд: Дорнод аймгийн 78 өвлөн уламжлагч, Хэнтий аймгийн 106 өвлөн уламжлагч, Сүхбаатар аймгийн 79 өвлөн уламжлагч, Улаанбаатар хотын 100 өвлөн уламжлагч, нийт 363 өвлөн уламжлагч хамрагдсан байна. Судалгаагаар Сүхбаатар аймгийн 424GB, Хэнтий аймгийн 703GB, Нийслэлийн 1791 MB хэмжээтэй гэрэл, зураг дүрс бичлэгийн цахим сан бий болов. | 100 |
| Зорилт 2.3. Соёлын биет өв, түүхэн дурсгалт барилга, архитектурын дурсгалыг судлах, судалгаа шинжилгээний үндсэн дээр сэргээн засварлана. (СӨХ тухай хуулийн 20.3 дугаар заалт) | | | | | | | | | |
| 15 | 2.3.1 | Нийтийн өмчийн түүх, соёлын дурсгалт зүйлийг эзэмшигчийн хүсэлтийн дагуу газар дээр нь болон өөрийн тусгай байрны лаборатори, урланд сэргээн засварлаж, хүлээлгэн өгнө. | Байгууллагын төсөв | Сэргээн засварлалтад хамрагдсан байгууллагын тоо. Сэргээн засварласан хөдлөх дурсгалт зүйлийн төрөл, тоон дүн. | 2021 онд 11 байгууллагын 33 үзмэр, эд өлгийн зүйлийг сэргээн засварласан. | Нийт 15 байгууллагын 60 ширхэг үзмэр сэргээн засварлагдсан байна. | | Соёлын биет өвийг сэргээн засварлах газар | Улс, аймгийн 25 музей/байгууллагын 163 ширхэг үзмэр, эд өлгийн зүйлс сэргээн засварлагдсан. Үүнд:<br>- Даавуу, зөөлөн эдлэл 41 ш, металл эдлэл 10ш, модон эдлэл 29ш, арьсан эдлэл 6ш, уран зураг 6ш, баримал 10ш, шаазан эдлэл 1ш, танка зураг 11ш, цаасан эдлэл 5ш, археологийн олдвор 6ш тус тус байна.<br>- ЭрдэнэЗуу музейн хүсэлтээр 38 ш шавар шуумал, гипс, модон баримлыг газар дээр нь очиж сэргээн засварласан.<br>Зорилтот түвшинтэй харьцуулбал сэргээн засварлалтад хамрагдсан байгууллагын тоо 166,66 %, үзмэрийн тоо 271,66 %- тай биелсэн үзүүлэлт гарч байна. | 100 |
| 16 | 2.3.2 | Яаралтай авран хамгаалах археологийн малтлага судалгаанаас илэрсэн олдвор, эд өлгийн зүйлийг байгууллагын хүсэлтээр бэхжүүлэх, цэвэрлэх, ажлыг газар дээр нь болон өөрийн тусгай байрны лаборатори, урланд хийж, хүлээлгэн өгнө. | Яамны нэмэлт санхүүжилт<br><br>5,606.0 | Хамрагдсан байгууллагын тоо.<br>-Бэхжүүлэлт, анхан шатны цэвэрлэгээ хийсэн олдвор, эд өлгийн зүйлсийн төрөл, тоон дүн. | 2021 онд археологийн малтлага судалгаанаас илэрсэн 179 ширхэг олдворт цэвэрлэгээ, бэхжүүлэлт хийсэн. | Археологийн хээрийн малтлага судалгаанаас илэрсэн 200 хүртэлх олдворт хадгалалт хамгаалалт, цэвэрлэгээ, бэхжүүлэлт, сэргээн засварлалт хийсэн байна. | | Соёлын биет өвийг сэргээн засварлах газар | Яаралтай аврах хамгаалах, археологийн олдворыг бэхжүүлэх ажлын хүрээнд 3 байгууллагын 206 эд өлгийн зүйлийг цэвэрлэх, бэхжүүлэх ажлуудыг хийсэн.<br>- Чингис хаан музейн үзмэрийн шавар 77 ш, чулуун 15 ш, яс 14 ш, гууль 28 ш нийт 134 үзмэрийг яаралтай сэргээн засварласан.<br>- МУИС-ийн хүсэлтээр Сүхбаатар аймаг Онгон сум, Таван толгойгоос илрүүлсэн 51 дэсийн 71 ширхэг биет өвийг тээвэрлэх сав баглаа боодол хийж, аюулгүй тээвэрлэх нөхцөлийг хангасны үндсэн дээр тус Үндэсний төвийн лабораторит авчирч хадгалалт хамгаалалт, судалгаа шинжилгээний ажлыг эхлүүлсэн.<br>- Өвөрхангай аймгийн Хархорин сумын нутагт орших Хархорум музейд Хар балгасын малтлагаас илэрсэн модон эдлэлийн гадаргуу хэсгийн талстыг сахрын уусмалаар цэвэрлэн хадгалалт хамгаалалтын нөхцөлийг сайжруулсан. | 100 |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 17 | 2.3.3 | Байгаль дээр ил задгай орших эвдрэл гэмтэлтэй чулуун дурсгалыг цэвэрлэх, бэхжүүлэх, сэргээн засварлах, хэв хуулбар хийх ажлыг аймаг орон нутгийн хүсэлтээр газар дээр нь болон өөрийн байранд хийж гүйцэтгэнэ. | Яамны нэмэлт санхүүжилт<br><br>8,606.500 | Хамрагдсан аймгийн тоо.<br>-Цэвэрлэж, бэхжүүлж, сэргээн засварласан<br>-Хэв хуулбар авагдсан чулуун дурсгалын төрөл, тоон дүн. | Анх удаа | 8 хүртэлх чулуун дурсгал хамруулна.<br><br>Дурсгалын эх төрх байдал сэргээгдсэн байна. | | Соёлын биет өвийг сэргээн засварлах газар | Ажлын хүрээнд дараах 4 аймгийн 3 дурсгалд цэвэрлэх, бэхжүүлэх ажиллагаа, 2 дурсгалын хэв хуулбар авах хийх ажлыг гүйцэтгэв.<br>- Завхан аймгийн Нөмрөг сумын нутаг Өвөр шивэртийн голоос 3 хэсэг хугарсан буган чулууг татан гаргаж механик цэвэрлэгээ хийж, тус аймгийн музейтэй хамтран Ялаат нуурын зүүн эрэгт орших буган чулуун дурсгал бүхий газарт зөөн аваачиж, байрлуулсан.<br>- Хөвсгөл аймгийн Бүрэнтогтох сумын Уушигийн өврийн 9 дүгээр буган чулуун хөшөөнд сэргээн засварлалт хийв. Сэргээн засварлах ажлыг хүрээнд Уг хөшөөний дээд талын залгагдах хэсэг нь шувууны сангасны бохирдлыг этилийн спирт, хөвөн, бийр, сойз гар багаж зэргийг ашиглаж цэвэрлэсэн. Чулууны овор хэмжээнд тохируулж мяндсан (файбер) арматур, титан (резьбатай) савхан бэлдэцээр холбогч шаантаг суулгасан. Шаантаг суулгах хэсгүүдийг тааруулж өрөмдөөд AKEPOX 2010 A+B чулууны цавуугаар нааж холбосон. Залгаас хэсгийн дутаж алга болсон хэсгүүдийг нөхөж дүүргэлт хийв.<br>- Говьсүмбэр аймгийн Шивээговь сумын 2 дугаар багийн нутаг Чойрын Богд уулын ханан хаданд зурсан, "улсын" хамгаалалтад байх жагсаалтад бүртгэгдсэн "Дагвасүндэл" бурхны зургийг гэмтээсэн байдалд шинжээчийн дүгнэлт гаргасан ба уг дурсгалыг алтан боронзоор будаж бохирдуулсаныг арилгаж сэргээн засварлах, цэвэрлэх ажил хийв.<br>- Архангай аймгийн музейн хашаанд байрлах "Бугатын гэрэлт хөшөө"-ний хуулбар (Үндэсний төвд хадгалагдаж байсан)-ыг сэргээн засварласан.<br>- Архангай аймгийн Хашаат сумын нутаг "Хөшөө цайдам"-д орших Түрэгийн үеийн "Культегин"-ний хөшөөний толгойн хуулбараас хэв авч баримал цутгасан. | 100 |
| 18 | 2.3.4 | Түүхэн дурсгалт барилга, архитектурын , дурсгалын сэргээн засварлалтын үйл ажиллагаанд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, зөвлөн тусалж, хамтран ажиллана. | Байгууллагын төсөв | Хамрагдсан түүхэн дурсгалт барилга, архитектурын, дурсгалын тоо.<br><br>Зөвлөсөн ажлын тоо.<br><br>Хяналт шинжилгээ хийсэн ажлын тоо.<br><br>Дүгнэлт гаргасан тоо<br><br>Сэргээн засварлалтад хамтран ажилласан тоо. | Анх удаа | 3 хүртэлх сүм хийд, дурсгалт уран барилга дээр ажилласан байна. | I-IV | Соёлын биет өвийг сэргээн засварлах газар<br><br>Соёлын өвийг авран хамгаалах газар | АНУ-ын Элчин сайдын нэрэмжит соёлын өвийг хамгаалах сангийн санхүүжилтээр Монголын Урлагийн зөвлөлөөс 2021 онд "Энэржин" ХХК-д тэтгэлэг олгож, Чойжин ламын сүм музейн "Ядамын сүм"-ийн сэргээн засварлалтын ажлыг гүйцэтгэлтэй танилцан явцыг зургаар баримтжуулсан. Чойжин ламын сүм музейн барилгын хийцийн бүх гол үндсэн эдлэгдэхүүнүүдийг сорьцын шинжилгээнд оруулж найрлагыг тодорхойлуулсан тухай, мөн дээврийн сольж байгаа хавтан ваарын шинжилгээний бичиг зэрэг холбогдох баримтуудыг үзэж танилцав. Тус ажлын хүрээнд Монголын Урлагийн зөвлөлийн Соёлын өвийн хөтөлбөрийн захирал Д.Баянмөнх болон "Энэржин" ХХК-ний захирал Д.Тулга нартай уулзаж, цаашид сүмийн сэргээн засварлалтын ажилд "Түүх, соёлын дурсгалыг сэргээн засварлах ажил гүйцэтгэх журам", барилгын норм дүрэм болон стандартыг хангаж ажиллахыг анхааруулав. Сэргээн засварлалтыг хийж буй "Энэржин" ХХК-иас ирүүлсэн хүсэлтийн дагуу тус музейн "Ядам сүм"-ийн гадна болон дотор талын цэвэрлэгээнд мэргэжлийн зөвлөгөө өгч, хамтран ажилласан.<br>- Богд хааны ордон музейн Лаврин, Чойжин ламын сүм музейн Ядам зэрэг 2 сүмийн барилгаас 25 байршил цэгт өнгө будгийн дээж авч байгалийн гаралтай шороон будгийг орчин үеийн багаж ашиглан лабораторид судалснаар, тухайн цаг үед хэрэглэж байсан өнгө будгийн эрдэс, цавуулаг, давхаргын найрлага тогтоосон байна. | 100 |
| 19 | 2.3.5 | Дүрслэх урлагийн музей, Улсын драмын эрдмийн театр, Дуурь бүжгийн эрдмийн театрын барилгыг хүчитгэх ажилд хамтран оролцох. | | Зөвлөсөн ажлын тоо.<br><br>Судалгаа хийсэн байдал.<br><br>Хамтран ажилласан байдал. | Анх удаа | 3 барилгын хүчитгэлийн ажилд хамтран оролцсон байна. | I-IV | Соёлын биет өвийг сэргээн засварлах газар<br><br>Соёлын өвийг авран хамгаалах газар | Улсын Дуурь бүжгийн эрдмийн театрийн барилгын гадна засварын гүйцэтгэлийн ажилтай 2022 оны 11 дүгээр сарын 21, 26-ны өдрүүдэд танилцаж театрын хойд талын гадна хана, карнизийн доод хэсэгт байрлах гурван төрлийн 75 ширхэг маскын сэргээн засварласан байдал болон засварлаж амжаагүй гурван талын хананы маск, баримлуудын одоогийн нөхцөл байдлыг гэрэл зургаар баримтжуулж авсан. Тус театрын барилгын засварлагдаж эхлээд буй хэсэглэлүүдийг харьцуулах эх зураг, маскын дүрслэл, баримлын хийцлэлтэй холбогдох түүхэн баримт материал манай байгууллагын архивт байхгүй тул анхны төрх байдал алдагдсан гэж үзэх нотолгоо баримт батлагдаагүй. 2022 оны 02/458 тоот албан бичгээр тус барилгын гадна засварын ажилд зөвлөмж хүргүүлэв. | 70 |
| Зорилт 2.4. Цаг үеийн шаардлагаар нэн яаралтай соёлын өвийг хадгалах, авран хамгаалах үйл ажиллагааг орон нутаг, мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулна. (СӨХ тухай хуулийн 20.3 дугаар заалт, 27.8 дахь заалт) | | | | | | | | | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 20 | 2.4.1 | Улс, аймаг, нийслэлийн хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалын хадгалалт хамгаалалт, ашиглалтын нөхцөл байдлын үнэлгээний судалгааг тусгай маягт ашиглан, бүсчлэн зохион байгуулж, дүн мэдээ үр дүнг Соёлын сайдад танилцуулна. | Яамны нэмэлт санхүүжилт<br><br>12,135.0 | Хадгалалт хамгаалалт, ашиглалтын нөхцөл байдлын үнэлгээнд хамрагдсан аймаг, тоо.<br><br>Судалгаанд хамрагдсан түүх, соёлын үл хөдлөх дурсгалын төрөл, тоон дүн.<br><br>Дурсгалд үнэлгээ | Анх удаа | 4-6 аймгийн нутагт орших "Улс, аймаг, нийслэлийн хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалт"-д бүртгэгдсэн 120 хүртэлх үл хөдлөх дурсгалд үнэлгээний судалгаа хийгдсэн байна.<br><br>120 хүртэлх дурсгал тус бүрд үнэлгээ тогтоосон байна. | II-III | Соёлын өвийн бүртгэл, судалгааны газар<br><br>Соёлын өвийг авран хамгаалах газар | Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын төрөл зүйл тус бүрийн онцлогт тохирсон хадгалалт хамгаалалтын мэдээлэл цуглуулах маягт боловсруулан Архангай, Баянхонгор, Булган, Дорноговь, Дундговь, Өмнөговь, Увс зэрэг 7 аймгийн нутаг дэвсгэр дэх улсын болон аймаг, нийслэлийн хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалтад бүртгэгдсэн 72 дурсгалт газрын 208 дурсгалын хадгалалт хамгаалалтын үнэлгээг хийсэн. Хадгалалт хамгаалалтын нөхцөл байдлын үнэлгээгээр 23 дурсгалт газар "сайн", 27 дурсгалт газар "дунд", 16 дурсгалт газар "муу", 6 дурсгалт газар "маш муу" хэмээн үнэлэгдсэн байна.<br>Үнэлгээний ажлын хүрээнд цугларсан мэдээллийг нэгтгэн Соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн санд хадгалсан ба судалгааний үр дүн мэдээг Соёлын яаманд хүргүүлэхээр бэлтгэж байна. | 100 |
| 21 | 2.4.2 | Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын хамгаалалтын хашаа, хайсны үлгэрчилсэн загвар, хийцлэлийн заавар боловсруулан баталж, аймгийн Соёлын газарт хүргүүлсэн байна. | Байгууллагын төсөв | Хашаа, хайсны загвар, хийцлэл боловсруулсан, баталсан, загварыг түгээсэн байдал. | Анх удаа | Загвар, хийцлэлийн заавар батлагдсан байна.<br>21 аймаг, нийслэлийн Соёлын газарт хүргүүлсэн байна. | I-IV | Соёлын биет өвийг сэргээн засварлах газар<br><br>Соёлын өвийг авран хамгаалах газар | Түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг хүн, мал амтны хөл, авто машин зэрэг байгаль, нийгмийн сөрөг хүчин зүйлсээс хамгаалах зорилгоор төмөр хайсан хашааны үлгэрчилсэн загвар, барих аргачлал боловсруулан аймаг, нийслэлийн Соёл, урлагийн газарт 2022 оны 6 дугаар сарын 8-ны 01/213 тоот албан бичгээр хүргүүлсэн. Хамгаалалтын хашааны бэлдэц нь төв, орон нутгийн зах зээлд элбэг олдоцтой, загвар нь дурсгалын эх төрхийг алдагдуулахгүй, энгийн бөгөөд барьж угсрах арга ажиллагаа болон засаж сэлбэхэд хялбар байхаар аргачлалд тусгасан.<br>Түүх, соёл, шинжлэх ухааны хувьд чухал ач холбогдолтой, эрсдэлд орсон дангаараа болон цогц байдлаар орших хөшөө дурсгал, булш, тахил тайлгын байгууламж, балгас, эртний хотын туурь, бага хэмжээтэй талбай бүхий дурсгалт барилга зэрэгт хамгаалалтын хашаа хайс барих шаардлагатай байна. Хамгаалалтын хашаа, хайстай болгосноор дурсгалын хадгалалт хамгаалалтын нөхцөл байдал сайжрах юм. | 100 |
| 22 | 2.4.3 | Цаг үеийн шаардлага, шийдвэрээр соёлын биет өвийг авран хамгаалах үйл ажиллагааг бусад байгууллагатай хамтран зохион байгуулж, үр дүнг тайлагнана. | Яамны нэмэлт санхүүжилт<br><br>27,775.0 | Хамрагдсан аймгийн нэр, тоо.<br><br>Авран хамгаалагдсан соёлын биет өвийн төрөл тоон дүн. | 2018-2021 онд 15 соёлын биет өвийг авран хамгаалах үйл ажиллагаа хийсэн. | Соёлын биет өвийг авран хамгаалах 5 хүртэлх үйл ажиллагааг хамтран хийсэн байна. | I-IV | Соёлын биет өвийг сэргээн засварлах газар<br><br>Соёлын өвийг авран хамгаалах газар | Сүхбаатар аймгийн Дарьганга сумын нутагт соёлын өв булагдсан гэх иргэдийн мэдээллийн дагуу шалгах, авран хамгаалах хээрийн судалгааг 8 дугаар сард зохион байгуулсан.<br>- Ховд аймгийн Үенч сумын нутаг Хараатын бэлчээрийн хадны зураг, Архангай аймгийн Ихтамир сумын нутаг Алтан тэвш уулын буган чулуун хөшөөдийн устах, соёлын өвийн үнэ цэнэ алдах эрсдэлийг бууруулах, авран хамгаалах үйл ажиллагааг зохион байгуулах зөвлөмж боловсруулан дээрх аймгийн Соёл, урлагийн газруудад хүргүүлсэн.<br>- Өмнөговь аймаг Сангийн Далай хийд, Өвөрхангай аймаг Хархорин сумын нутаг орших Шанхын Баруун хүрээ хийд, мөн сумын нутагт орших Мэлхий толгой 1 чулуун дурсгал, Төв аймаг Алтанбулаг сум, Өнгөтийн дурсгалуудад тус тус хүрээлэн буй орчны эрсдэлийн тандалт судалгааг хийж, арга зүй боловсруулсан.<br>- Чойжин ламын сүм музейн "Гомбо" танка зургийн өнгө будагт XRF химийн элементийн шинжилгээ, даавуун эдлэлийн гарал үүслийн судалгаа;<br>- Өвөрхангай аймаг Хархорин сум, ЭрдэнэЗуу хийдийн Лаврин сүмийн 130 ш дурсгалд гэмтлийн тодорхойлолт;<br>- Сүхбаатар аймаг Онгон сумын нутагт орших 13 дугаар зууны үеийн булш малтлагаас илэрсэн олдворын гэмтэл, цаашид хийгдэх сэргээн засварлалт, хадгалалт хамгаалалтын ажлын төлөвлөгөөг боловсруулж, булшнаас гарсан үр тарианы төрөл тодорхойлолт, эмээлд XRD, FTR, ICP, хөрсөнд механик бүрэлдэхүүн, химийн найрлага, даавуун эдлэлд нэхмэлийн ширхэглэг, төрөл зүйл тодорхойлолт, модон эдлэлд чийг тодорхойлох зэрэг судалгаа;<br>- Архангай аймгийн Өлзийт сум, Луут хотын малтлагаас авсан хөрсний дээжийн судалгааг тус тус хийж зохих тодорхойлолт, дүгнэлт, зөвлөмжийг гаргасан.<br>- Гадаад оронтой хамтын ажиллагааны хүрээнд Япон улсын Нара, Осака хотын хадгалалт хамгаалалт хүрээлэнгийн судалгааны багтай хамтран туршлага солилцох болон өнгө будгийн судалгааны ажлыг эхлүүлсэн. | 100 |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 23 | 2.4.4 | Яаралтай хамгаалах шаардлагатай өндөр настай соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчийн мэдлэг, арга ухааныг бүртгэл, судалгаа, гэрэл зураг, дүрс бичлэгээр баримтжуулж, мэдээллийн санд хадгална. | Байгууллагын төсөв | Хамрагдсан өвлөн уламжлагч хүний тоо, ай савын төрөл, зүйл.<br><br>Баримтжуулсан гэрэл зураг, дүрс бичлэгийн хэмжээ.<br><br>УНБМСанд хадгалсан байдал | Анх удаа | Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчийн үндэсний жагсаалтад бүртгэгдсэн, Яаралтай хамгаалах шаардлагатай соёлын биет бус өвийг өвлөн уламжлагч 10 хүртэлх хүний мэдлэг, арга ухааныг баримтжуулж, холбогдох судалгааг хийсэн байна. | I-IV | Соёлын өвийн бүртгэл, судалгааны газар<br><br>Соёлын өвийг авран хамгаалах газар<br><br>Мэдээллийн технологи, аюулгүй байдлын газар | 2022 оны тайлант хугацаанд Соёлын биет бус өвийг ур чадварын өндөр түвшинд өвлөн эзэмшсэн "Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчийн үндэсний жагсаалт"-д бүртгэгдсэн өндөр настай өвлөн уламжлагчийн мэдлэг, арга ухааныг гэрэл, зураг дүрс бичлэгээр баримтжуулав. Үүнд.<br>- Дархан-Уул аймгийн Орхон сумын Ардын язгуур урлаг, Уламжлалт арга ухаан ай сав хамаарах 2 өвлөн уламжлагчийн 32ш (0.27GB цахим файл) гэрэл зураг, (10.98GB цахим файл) 01:05:02 секундын дүрс бичлэг,<br>-Сэлэнгэ аймгийн Дулаанхаан, Түшиг, Зүүнбүрэн сумын Эх хэл, аман уламжлал, илэрхийлэл, Уламжлалт арга ухааан, Уламжлалт гар урлалын ай сав хамаарах 3 өвлөн уламжлагчийн 66ш (0.53GB цахим файл) гэрэл зураг, (70.83 GB8 цахим файл) 05:33:04 секундын дүрс бичлэг,<br>-Дундговь аймгийн манлай сумын Уламжлалт арга ухаан ай савд хамаарах 1 уламжлагчийн 77ш (0.59GB цахим файл) гэрэл зураг, (35.9GB цахим файл) 01:39:35 секундын дүрс бичлэг,<br>-Улаанбаатар хотын Чингэлтэй дүүргийн Ардын язгуур урлаг, Уламжлалт баяр наадам, зан үйл, ёс, тоглоом наадгай, уриа дуудлага ай сав хамаарах 2 өвлөн уламжлагчийн 89ш (10.6GB цахим файл), (35.1MB цахим файл), 00:42:12 секундын дүрс бичлэг,<br>- Улаанбаатар хотын Хан- Уул дүүргийн Уламжлалт гар урлалын ай савд хамаарах 1 өвлөн уламжлагчийн 52 ш (0.17 GB цахим файл), 11.2 GB дүрс,00:32:11 секундын дүрс бичлэг,<br>-Улаанбаатар хотын Сүхбаатар дүүргийн Ардын язгуур урлаг ай сав хамаарах (9,55 GB цахим файл) дүрс бичлэг, хэрэглэгдэхүүнийг УНБМСанд хадгалав. Баримтжуулалтад нийт Монгол Улсын Соёлын биет бус өвийн Төлөөллийн бүртгэлд орсон 7, Яаралтай хамгаалах шаардлагтай соёлын биет бус өвийн бүртгэлд орсон 3 өв, нийт 10 өв буюу нийт 3 аймаг, 4 сум, 3 дүүргийн 64-82 насны нийт 10 өвлөн уламжлагчийг хамруулсан байна. Баримтжуулалтын үр дүнд нийт 316 ш (1,75GB цахим файл), 92ш (142,58GB буюу 24MBцахим файл), 9 цагийн хэмжээтэй дүрс бичлэгийг цуглуулан СӨУНБМСанд хадгалав. | 100 |
| 24 | 2.4.5 | Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчийн үндэсний жагсаалтад батлагдсан 102 хүртэлх өвлөн уламжлагчийг эрүүл мэндийн үзлэгт хамруулах ажлыг зохион байгуулж, тайлагнана. | | Эрүүл мэндийн үзлэгт хамруулсан өвлөн уламжлагчийн тоо. | Анх удаа | Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчийн үндэсний жагсаалтад бүртгэгдсэн амьд сэрүүн байгаа өвлөн уламжлагчдыг эрүүл мэндийн үзлэгт хамруулах ажлыг оршин сууж буй харьяаллын дагуух эрүүл мэндийн даатгалын системтэй уялдуулан зохион байгуулсан байна. | I-IV | Соёлын өвийн бүртгэл, судалгааны газар<br><br>Соёлын өвийг авран хамгаалах газар | Тус ажлын хүрээнд Соёлын биет бус өвийг ур чадварын өндөр түвшинд өвлөн эзэмшиж, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 475 дугаар тогтоолоор "Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчийн үндэсний жагсаалт"-д батлагдсан 102 өвлөн уламжлагчийн харьяалал, холбоо барих дэлгэрэнгүй мэдээлэл, эрүүл мэндийн нөхцөл байдлийн судалгааг нэгтгэх ажлыг гүйцэтгэв. Судалгааны дүн мэдээгээр 26 өвлөн уламжлагч нас барсан, 76 өвлөн уламжлагч амьд сэрүүн байна гэсэн тоон үзүүлэлт гарсан. Амьд сэрүүн 76 өвлөн уламжлагчийн дэлгэрэнгүй мэдээллийг Соёлын яаманд хүргүүлж, судалгаанд суурилж эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд хамрагдах нэн шаардлагатай 50 өвлөн уламжлагчдыг оношлогоонд хамруулах ажлыг тус яамтай хамтран IV улиралд зохион байгуулав. Үр дүнд соёлын биет бус өвийг ур чадварын өндөр түвшинд өвлөн эзэмшсэн өвлөн уламжлагч нар эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд үнэ төлбөргүй хамрагдаж, өөрсдийн биеийн онцлогт тохирсон зөвлөгөө авч, эмчилгээ хийлгэв. | 100 |
| 25 | 2.4.6 | "Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц"-ын хамгаалалтын бүс дэх соёлын биет бус өвийн бүртгэл, судалгаа хийж, төрөлжсөн мэдээллийн сан үүсгэсэн байна. | Бусад санхүүгийн эх үүсвэрээс<br><br>"Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц"-ын төслийн нэгж | Хамрагдсан өрх айл,<br><br>Бүртгэгдсэн өвлөн уламжлагчийн тоо,<br><br>Бүртгэгдсэн соёлын биет бус өвийн төрлийн нэр, тоо. | Анх удаа | Хамгаалалтын бүс дэх 200 хүртэлх өрх айлыг хамруулсан байна.<br><br>Усан цахилгаан станцын бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлэхэд дэмжлэг үзүүлсэн байна. | I-IV | Соёлын өвийн бүртгэл, судалгааны газар<br><br>Соёлын өвийг авран хамгаалах газар | "Эрдэнэбүрэн"-УЦС баригдах Ховд аймгийн Мянгад, Эрдэнэбүрэн, Увс аймгийн Өмнөговь, Баян-Өлгий аймгийн Баян нуур сумдын нутагт нутаглан суугаа монгол угсаатны томоохон бие даасан бүлгүүд болох Мянгад, Өөлд, Дөрвөд, түрэг угсааны нэгэн бүлэг монголын Казахууд нарын соёлын биет бус өвийн сөрөг нөлөө болон тус бүс нутагт орших түүх, соёлын үл хөдлөх дурсгалын археологийн авран хамгаалах ажил, зарим дурсгалыг нүүлгэн шилжүүлэхэд анхаарах талаар төслийн нэгжид 2022 оны 01/262 тоот албан бичгээр зөвлөмж хүргүүлсэн. | 70 |
| 26 | 2.4.7 | Шүүхийн шийдвэрээр хураагдсан соёлын биет өвийг музейд шилжүүлэх ажлыг зохион байгуулж, гүйцэтгэлийг тайлагнана. | Байгууллагын төсөв | Хамрагдсан музейн нэр, тоо.<br><br>Шилжүүлсэн соёлын биет өвийн тоо | 2021 онд 1 аймгийн музейд 143 ширхэг хураагдсан соёлын биет өвийг шилжүүлсэн. | Холбогдох хууль, журмын дагуу соёлын биет өвийг музейд шилжүүлж, музейн бүртгэл, мэдээллийн санд бүртгэгдсэн байна. | I-IV | Соёлын өвийн бүртгэл, судалгааны газар | Тайлант хугацаанд Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь сум дундын шүүх, шийтгэх тогтоолоор хураах, улсын орлого болгох шийдвэр гарсан түүх, соёлын дурсгалт зүйлд хамаарах 1 ширхэг "Таван оройт титэм" эд зүйл ирснийг Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 52.8 дахь заалтын дагуу холбогдох төрийн захиргааны төв байгууллагаас зөвшөөрөл авч, Хэнтий аймгийн музейд шилжүүлэхээр бэлтгэл ажлыг хангаад байна. | 100 |
| Зорилт 2.5. Соёлын өвийн боловсрол олгох, соён гэгээрүүлэх, шавь сургалт зохион байгуулах, соёлын өвийг сурталчлах үйл ажиллагааг олон улс, хүүхэд залуучууд, олон нийтэд зориулан сэтгүүл, гарын авлага, цахим контент хэлбэрээр зохион байгуулна. (СӨХ тухай хуулийн 20.3, 24.2 дахь заалт) | | | | | | | | | | |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 27 | 2.5.1 | Соёлын өвийг сурталчлах, боловсрол олгох, шавь сургалт зохион байгуулах зорилгоор "Бага театр"-ыг ашиглалтад оруулж, хүүхэд залуучуудад соён гэгээрүүлэх, боловсрол олгох ажлыг эхлүүлнэ. | Бусад санхүүгийн эх үүсвэрээс<br><br>Рио Тинто Монгол компани<br><br>470,000.0 | Орчин үеийн тоног төхөөрөмжөөр тоноглогдсон байдал.<br><br>Суудлын тоо.<br><br>Үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулсан байдал. | Анх удаа | 100 хүртэлх хүний багтаамжтай бага театр ашиглалтад орж, үйл ажиллагаа эхлүүлсэн байна. | I-III | Захиргаа, удирдлагын газар<br><br>Соёлын өвийн бүртгэл, судалгааны газар | Монголын Урлагийн Зөвлөлийн дэмжлэг, "Рио Тинто" ХХКомпанийн 400 сая төгрөгний санхүүжилтээр "Өв Эрдэнэ" театрын интерьер дизайныг "Спринт Архитект" зураг төслийн компани боловсруулж, "Рэдлайн ХХК" дотоод заслын ажил гүйцэтгэж, тайзны гэрэлтүүлгийг D-Light компани, дуу хөгжмийн тоног төхөөрөмжийг "ITC Solution ХХК" суурилуулж 2022 оны 7 дугаар сарын 5-нд ашиглалтад хүлээлгэн өгсөн.<br>Монгол гэр мэт дугуй интерьер дизайнтай, үндэсний болон орчин үеийн загвар шийдэл бүхий 100 үзэгчдийн багтаамжтай, дэвшилтэт технологийн гэрэлтүүлэг, дуу хөгжмийн тоног төхөөрөмжөөр тоноглогдсон ардын язгуур урлагийн ай сав дахь соёлын биет бус өвлөн уламжлагч нар зориулсан анхны төрөлжсөн театр гэдгээрээ онцлог юм.<br>Төрийн байгууллага, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагуудын түншлэлийн хүрээнд бүтээн байгуулсан энэхүү театрт соёлын биет бус өв, өвлөн уламжлагчийн урын сан, мэдлэгийг дуу, дүрс бичлэгээр баримтжуулах, ардын язгуур урлагийн тоглолт, хүүхэд залууст чиглэсэн соёлын өвийн боловсрол олгох сургалт, соёлын өвийн цуврал кино үзвэр, танин мэдэхүйн лекц, эрдэм шинжилгээний хурал, зөвлөгөөн, олон нийтийн уралдаан наадам зэрэг соёлын өвийг түгээн дэлгэрүүлэх үйл ажиллагааг аймаг, орон нутгийн соёл урлагийн газар, нутгийн зөвлөл, боловсролын байгууллага, төрийн бус байгууллага, өвлөн уламжлагчид зэрэг олон талын оролцогчтойгоор тогтмол зохион байгуулахаар төлөвлөсөн. Театр нээгдсэнээс хойш "Монгол цуур хөгжмийн уламжлалт урлаг"-ийг сурталчлах өдөрлөг, шилдэг өвлөн уламжлагч Г.Баяртайн "Дөрвөд, баяд бий биелгээний шавь сургалт"-ын төслийн тайлан тоглолт, "Олон угсаатны соёлын өв-Буриад ба Хамниган угсаатны соёл, уламжлал" лекц зэрэг арга хэмжээнүүдийг зохион байгуулсан ба соёлын биет бус өвийг хадгалж хамгаалах, сурталчлах, сургалт, судалгаа, бүртгэн баримтжуулалт хийх "Өв Эрдэнэ" театрын зорилтот үйл ажиллагааны 2023 оны календарьчилсан төлөвлөгөөг боловсруулсан. | 100 |
| 28 | 2.5.2 | Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн хүрээнд зүүн 3 аймгийн нутагт байх улс, аймгийн хамгаалалтын түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг танилцуулсан видео танилцуулга, баримтат нэвтрүүлгийг хийж, сошиал платформд байршуулж, олон нийтэд сурталчилна. | Байгууллагын төсөв ба бусад эх үүсвэр | Хамрагдсан аймгийн тоо.<br>3 хүртэлх минутын видео танилцуулга хийгдсэн дурсгалт газрын тоо.<br><br>Баримтат нэвтрүүлэг хийсэн тоо.<br><br>Байгууллагын вэб хуудаст байршуулсан байдал.<br><br>Телевизийн сувгаар сурталчилсан тоо. | Анх удаа | Дорнод, Сүхбаатар, Хэнтий, Говьсүмбэр, аймгийн 50 хүртэлх түүх, соёлын үл хөдлөх дурсгал хамрагдсан байна.<br>Сард 1-3 удаа танилцуулгыг олон нийтийн болон арилжааны телевиз, олон нийтийн цахим сүлжээ (сошиал платформ, фейсбүүк, ютуб гэх мэт)-гээр дамжуулан олон нийтэд хүргэсэн байна. | I-IV | Соёлын өвийн бүртгэл, судалгааны газар<br><br>Мэдээллийн технологи, аюулгүй байдлын газар | Зүүн бүсийн (Хэнтий, Дорнод, Сүхбаатар аймаг) нутаг дэвсгэрт орших Улс, аймаг, нийслэлийн хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалтад батлагдсан 30 дурсгалт газрын тайлбар, танин мэдэхүйн танилцуулга (1-3 хүртэлх) бүхий видео контентыг тус Үндэсний төвийн сошиал сувгаар дамжуулан олон нийтэд сурталчлав. Тус ажлын хүрээнд: Хэнтий аймгийн нутаг дэвсгэр дэх Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалтад батлагдсан 11 дурсгалт газар, Аймгийн хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалтад батлагдсан 5 дурсгалт газар, Дорнод аймгийн нутаг дэвсгэр дэх Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалтад батлагдсан 3 дурсгалт газар, Аймгийн хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалтад батлагдсан 4 дурсгалт газар, Сүхбаатар аймгийн нутаг дэвсгэр дэх Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалтад батлагдсан 7 дурсгалт газар нийт 30 дурсгалт газрын жагсаалт, агуулгыг боловсруулав.<br>Дээрх аймгийн нутаг дэвсгэр дэх Улс, аймаг, нийслэлийн хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалтад батлагдсан 30 дурсгалт газрын нийт 01:09:38 хугацаатай, 4.96 GB хэмжээтэй цахим файлыг Соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл мэдээллийн санд хадгалав.<br>Монголын Бурханы Шашинтны Төв Гандантэгчэнлин хийдэд хадгалагдаж буй түүх, соёлын хосгүй үнэт 5 дурсгалт зүйл (Очирдара 2ш, Майдар 2ш, Сосорбарам)-ийн 1-3 минутын дүрс бичлэг, тайлбар бүхий видео контентыг бэлтгэн олон нийтэд GTV сувгаар сурталчилж байна.<br>Арилжааны телевиз болон цахим сүлжээ ашиглан соёлын өв, дурсгалыг сурталчилснаар олон нийтийн мэдлэг ойлголт дээшилж, дурсгалын хадгалалт хамгаалалтад эерэг нөлөө үзүүлнэ. | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 29 | 2.5.3 | Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн хүрээнд соёлын биет бус өвийн төрөл зүйлийг танилцуулсан видео танилцуулга хийж, сошиал платформд байршуулж, олон нийтэд сурталчилна. | Байгууллагын төсөв ба бусад эх үүсвэр | 3 хүртэлх минутын видео танилцуулга-контент хийгдсэн соёлын биет бус өвийн төрөл зүйлийн тоо.<br><br>Байгууллагын вэб хуудаст байршуулсан байдал. | 2021 онд 30 видео танилцуулга хийгдсэн. | Соёлын биет бус өвийн 15 хүртэлх видео танилцуулга хийгдсэн байна.<br><br>Олон нийтийн цахим сүлжээ (сошиал платформ, фейсбүүк, ютюб гэх мэт)-гээр дамжуулан олон нийтэд хүргэсэн байна. | I-IV | Соёлын өвийн бүртгэл, судалгааны газар<br><br>Мэдээллийн технологи, аюулгүй байдлын газар | ЮНЕСКО-гийн соёлын биет бус өвийн Төлөөллийн болон Яаралтай хамгаалах шаардлагатай 15 өв, Монгол улсын соёлын биет бус өвийн төлөөллийн үндэсний бүртгэлийн 15 өв нийт 30 соёлын биет бус өвийн танилцуулга бүхий 3 хүртэлх минутын видео контентыг олон нийтийн соёлын биет бус өвийн танин мэдэхүйн хэрэгцээнд тулгуурлан Соёлын өвийн үндэсний төвийн платформд байршуулав. Тус ажлын хүрээнд: ЮНЕСКО-ийн соёлын биет бус өвийн Төлөөллийн жагсаалтад бүртгэгдсэн 8 өв, Яаралтай хамгаалах шаардлагатай 7 өв, Монгол Улсын Монгол улсын соёлын биет бус өвийн төлөөллийн үндэсний бүртгэлийн 15 өв нийт 30 соёлын биет бус өвийн агуулгын боловсруулсан.<br>Эх хэл, аман уламжлал, илэрхийллүүд ай савын 2 өв, Ардын язгуур урлаг 9 өв, Уламжлалт баяр наадам, зан үйл, ёс, тоглоом наадгай, уриа дуудлага 9 өв, Байгалийн болон сав шим ертөнцийн тухай мэдлэг, зайн үйл 1 өв, Уламжлалт арга ухаан 7 өв, Уламжлалт гар урлал 2 өв нийт 30 соёлын биет бус өвийн 01:20:35 хугацаатай, 5 78 GB багтаамж бүхий цахим файлыг соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн санд хадгалав. | 100 |
| 30 | 2.5.4 | Соёлын өвийн мэдээ, мэдээлэл сэтгүүл болон соёлын өвийг бүртгэх, хадгалж хамгаалах арга зүйн гарын авлага хэвлэн, соёлын байгууллага, соёлын өвийн ажилтан, олон нийтэд түгээнэ. | Байгууллагын төсөв | Гарын авлагын төрөл, тоо.<br><br>Хэвлэсэн тоо<br><br>Олон нийтэд түгээсэн байдал. | 2021 онд "Соёлын өвийн мэдээ, мэдээлэл" сэтгүүл 9 дэх цуврал гарсан.<br><br>2021 онд хадгалалт хамгаалалтын чиглэлээр 1 гарын авлага хэвлэгдсэн. | 60 нүүр бүхий "Соёлын өвийн мэдээ, мэдээлэл" сэтгүүлийн 10 дэх цуврал гарсан сэтгүүл гарч олон нийтэд хүрсэн байна.<br><br>"Баримтат өвийн бүртгэл",<br>"Гамшгийн үед соёлын өвийг нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөө"-ний гарын авлага" зэрэг 3 хүртэлх соёлын өвийг хамгаалах арга зүйн гарын авлага хэвлэсэн байна. | I-III | Соёлын өвийн бүртгэл, судалгааны газар<br><br>Мэдээллийн технологи, аюулгүй байдлын газар | "Монгол Улсын баримтат өвийн бүртгэл"-д нэр дэвшүүлэх дурсгалыг бүртгэх аргачлал гарын авлагыг боловсруулж, хянуулж хэвлэхэд бэлэн болгосон. Цаасны хэмжээ А/6 86 нүүр бүхий аргачлал, зөвлөмж багтаж байгаа бөгөөд 2022 онд багтаж Соёлын яамны санхүүжилтээр хэвлэгдэнэ. Уг "Монгол Улсын баримтат өвийн бүртгэл"-д нэр дэвшүүлэх дурсгалыг бүртгэх аргачлал гарын авлагын цахим хувилбарыг тус Үндэсний төвийн ncch.gov.mn цахим хуудсанд байршуулсан.<br>- ЮНЕСКО-гийн Соёлын өвийн хадгалалт, сэргээн засварлалт, судалгааны олон улсын төвөөс музейн үзмэр, эд өлгийн зүйлсийг онцгой нөхцөлд нүүлгэн шилжүүлэхэд зориулсан Emergency Evacuation of Heritage Collections (Эрсдэлийн үед соёлын өвийг нүүлгэн шилжүүлэх) гарын авлагыг англи хэлнээс орчуулж түгээх оюуны өмчийн эрхийн зөвшөөрлийг тус байгууллагаас албан ёсны эрхтэй хэвлэн, түгээв. Тус бүтээл нь А5 хэмжээтэй, 56 нүүр бүхий удиртгал, үнэлэх, Бэлтгэх, Баримтжуулаад, савлаад хөдлөх, Нүүлгэн шилжүүлэх, хадгалах гэсэн 5 дэд сэдэвт агуулгатай бөгөөд музейн тухай хуульд заасанчлан музейн сан хөмрөгийг гамшиг болон аюулын үед нүүлгэн шилжүүлэх журмыг боловсруулахад гарын авлага, эх сурвалж болох юм. | 100 |
| 31 | 2.5.5 | Соёлын биет бус өвийн олон улс, бүсийн хэмжээний уралдаан наадам зохион байгуулахад мэргэжил арга зүй, бүртгэл судалгаа, баримтжуулалтын чиглэлээр хамтран оролцож, соёлын өвийг мэдээллийн сан үүсгэнэ. | Байгууллагын төсөв | Хамтран ажилласан соёлын биет бус өвийн уралдаан, наадмын тоо.<br><br>Бүртгэл судалгаа, баримтжуулалт хийсэн тоон дүн, хэмжээ. | Анх удаа | 2022 онд 3 хүртэлх уралдаан, наадамд хамтран оролцсон байна. | II-III | Соёлын өвийн бүртгэл, судалгааны газар<br><br>Мэдээллийн технологи, аюулгүй байдлын газар | ЮНЕСКО-гийн санхүүжилтээр хэрэгжсэн "Монгол ардын уртын дуу лимбэдэх уламжлалт арга-битүү амьсгааг хойч үед өвлүүлэн уламжлуулах, тогтворжуулах нь" төслийн хүрээнд өвлөн суралцагчдын дунд 2022 оны 6 дугаар сард уралдаант наадам, үзлэг зохион байгуулж, олон нийтэд түгээн сурталчлав. Үүнд: "Монгол уртын дуу лимбэдэх уламжлалт арга-Битүү амьсгаа өвийг өвлөн суралцагчдын Анхдугаар уралдаан"-нд Улаанбаатар хот болон Говь-Алтай, Дорноговь, Завхан, Өвөрхангай, Өмнөговь, Сэлэнгэ, Хөвсгөл зэрэг 7 аймгийн нийт 11 багш, 40 шавь суралцагч оролцсон, "Уртын дуу лимбэдэх уламжалт арга битүү амьсгаа-Тогтвортой хөгжил" Эрдэм шинжилгээ-Онол практикийн бага хурал, "Монгол уртын дуу лимбэдэх уламжлалт арга-битүү амьсгаа" Гала тоглолт, "Монгол лимбэчид ба өвлөн уламжлагчид" Монгол лимбэчдийн намтар, танилцуулга бүхий 500 ш ном, "Монгол лимбэчдийн бүтээлийн дээжис" СД 300 ш байна.<br>- Дорнод аймгийн Хөлөнбуйр суманд зохион байгуулагдсан "Баргажин -2022" наадамд мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч, өвлөн уламжлагчийг баримтжуулан нийт 24GB гэрэл зураг, 300 GB дүрс бичлэгийн баримтжуулалт хийв.<br>- "Нүүдэлчин Монгол 2022" Соёлын биет бус өвийн наадмын хүрээнд "Соёлын өвийн хүрээ" – "Нүүдлийн соёл иргэншлийн үнэт зүйлс- Хүн төрөлхтний соёлын биет бус өв" өргөөний үйл ажиллагааг хариуцан ажиллахын сацуу тус наадмыг зохион байгуулах, шүүх, Соёлын яамны харьяа байгууллагуудыг арга зүйгээр хангаж ажиллав<br>- Хэнтий аймгийн Батноров суманд жил бүр уламжлал болгон зохион байгуулагддаг "Талын түмэн адуу-2022" соёл, аялал жуулчлалын эвентийн хүрээнд Соёлын яам, Соёлын өвийн үндэсний төв, ШУА-ийн Археологийн хүрээлэн, Чингис хааны өв соёлын хүрээлэн хамтран соёлын биет болон биет бус өвийг сурталчлан таниулах, түгээн дэлгэрүүлэх зорилгоор соёлын өвийн танин мэдэхүйн мэдлэг, ойлголт, Монгол уран дархан, Батноров хийцийн онцлог, уламжлал, Батноров хийцийн бүтээлийн танилцуулгыг олон нийтэд хүргэж зохион байгуулсан. | 100 |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 32 | 2.5.6 | "Соёлын бүтээлч сар" төрөлжсөн үйл ажиллагааг зохион байгуулж, төрөлжсөн хэлэлцүүлэг зохион байгуулж, үр дүнг олон нийтэд сурталчилж, тайлагнана. | Яамны нэмэлт санхүүжилт<br><br>8,000.0 | Зохион байгуулсан арга хэмжээний тоо.<br><br>Хамрагдсан хүний тоо. | Сүм хийд сэргээн засварлалт, соёлын өвийн үнэлгээний чиглэлээр 2021 онд анх удаа зохион байгуулагдсан. | "Уул уурхай ба соёлын өвийн эрсдэл", "Газрын харилцаан дахь соёлын өвийн хамгаалал", "Дурсгалт уран барилгын сэргээн засварлалтын чадавх", "Соёлын өвийн эсрэг гэмт хэргийн нөхцөл байдал<br>гэсэн 4<br>чиглэлээр төрөлжсөн хэлэлцүүлэг зохион байгуулж, олон нийтэд танилцуулж мэдээлсэн байна. | II-IV | Соёлын өвийн бүртгэл, судалгааны газар<br><br>Соёлын өвийг авран хамгаалах газар<br><br>Мэдээллийн технологи, аюулгүй байдлын газар | Соёлын өвийн судалгаа, хадгалалт хамгаалалт, өнөөгийн байдлын олон талт сэдвийн хүрээнд 1 эрдэм шинжилгээний хурал, 1 зөвлөгөөн, 3 хэлэлцүүлэг, 2 сургалт, хүүхэд залуусын соёлын боловсролд зориулсан 3 сурталчилгааны ажлыг Соёлын яам, бусад холбогдох газрууд болон Үндэсний төв бие даан зохион байгуулсан.<br>- "Монголын уламжлалт анагаах ухаан" эрдэм шинжилгээний хурал, бэсрэг үзэсгэлэн, (танхим, цахим 80 оролцогч);<br>- "Соёлын өв-тогтвортой хөгжил" соёлын өвийн улсын хоёрдугаар зөвлөгөөн (танхим, цахим 130);<br>- "Түүх, соёлын үл хөдлөх дурсгал ба газрын харилцаа" хэлэлцүүлэг (танхим, цахим 87);;<br>- "Архитектурын өвийг хадгалж, хамгаалах нь" хэлэлцүүлэг (танхим, цахим70);<br>- "Дэлхийн өв-Орхоны хөндийн дурсгалт газар дахь уур амьсгалын өөрчлөлт, түүнд соёлын өвийн өртөх байдал, эрсдэл сэдэвт судалгааны ажлын үр дүн" хэлэлцүүлэг (танхим, цахим 65);<br>- "Соёлын өвийн мэдлэг, ойлголт" сургалт (танхим, цахим 40 оролцогч );<br>- "Трехалос сахарын уусмалыг соёлын өвийн хадгалалт хамгаалалтад ашиглах нь" сургалт (танхим, цахим 30 оролцогч );<br>Соёлын яам болон бусад холбогдох чиглэлийн яам, агентлаг, аймаг, нийслэлийн соёл, урлагийн газар, төрийн болон төрийн бус байгууллагууд, их дээд сургууль, эрдэмтэн судлаачид, мэргэжилтэнгүүд зэрэг нийт 502 төлөөлөл оролцож, хэлэлцсэн сэдвээр соёлын өвийн өнөөгийн тулгамдаж буй асуудал, цаашдын баримтлах бодлого төлөвлөлтийн санааг зөвшилцөн ойлголтыг нэгтгэв.<br>- "Олон угсаатны соёлын өв" сэдвийн хүрээнд "Дөрвөд, баяд бий биелгээ" өвийг сурталчлах өдөрлөг, "Урианхай түмний соёл", "Буриад, Хамниган угсаатны уламжлалт соёл" сэдэвт цуврал арга хэмжээг зохион байгуулж 350 орчим иргэнд таниулан сурталчилав.<br>- "Соёлын өвийг хайрлан хамгаалагч" боловсролын ажлын нээлттэй долоо хоног (ЕБС-ийн 118 дугаар сургууль, Хан-Уул дүүргийн Хүүхдийн зөвлөлийн 115 сурагч) | 100 |
| 33 | 2.5.7 | "Соёлын биет бус өвийг үндэсний болон дэлхийн хэмжээнд сурталчлан алдаршуулах, түгээн дэлгэрүүлэхэд онцгой хувь нэмэр оруулсан өвлөн уламжлагчид мөнгөн шагнал олгох журам"-ын хэрэгжилтийг хангаж, Соёлын яаманд нэр дэвшсэн өвлөн уламжлагчдын мэдээллийг нэгтгэн хүргүүлнэ. | | Хамрагдсан засаг захиргааны нэгжийн нэр, тоо.<br><br>Хамрагдсан соёлын биет бус өвийг өвлөн уламжлагч хүний тоо.<br><br>Хамрагдсан соёлын биет бус өвийн ай сав, төрөл зүйл.<br><br>Жилд 1 удаа зохион байгуулна. | 2019-2021 онд соёлын биет бус өвийн 3 шилдэг өвлөн уламжлагч шалгарч шагнуулсан. | Оны шилдэг соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчийг шалгаруулах материалыг хүлээн авах, нэгтгэх, холбогдох хүрээлэн, байгууллагуудад хүргүүлж санал авч нэгтгэн, мэдээллийг Соёлын яаманд хүргүүлсэн байна. | IV | Соёлын өвийн бүртгэл, судалгааны газар | Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 354 дүгээр тогтоолын хавсралт "Соёлын биет бус өвийг сурталчлан алдаршуулах, түгээн дэлгэрүүлэхэд онцгой хувь нэмэр оруулсан өвлөн уламжлагчид мөнгөн шагнал олгох журам"-ын дагуу шагналд нийт 19 өвлөн уламжлагч нэр дэвшсэн байна. Эдгээр 19 өвлөн уламжлагч нь эх хэл болон аман уламжлал илэрхийллүүд 2, ардын язгуур урлаг 4, үндэсний уламжлал зан үйл, ёслол, байр наадам 4, уламжлалт арга ухаан 1, ардын уламжлалт гар урлаг 8 байна. Нэр дэвшигчдээс Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 475 дугаар тогтоолоор "Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчийн үндэсний жагсаалт"-д бүртгэгдсэн 5 хүн байв.<br>Нэр дэвшсэн 19 өвлөн уламжлагчдыг тус бүрчлэн 8 байгууллагаас санал авах ажлыг зохион байгуулж 2022 оны 01 дүгээр сарын 18-ны өдөр Соёлын биет бус өвийн мэргэжлийн зөвлөлд хүргүүлсэн. 2021 онд Соёлын биет бус өвийг сурталчлан алдаршуулах, түгээн дэлгэрүүлэхэд онцгой хувь нэмэр оруулсан өвлөн уламжлагчаар Өвөрхангай аймгийн Баян-Өндөр сумын малчин, хөхүүр урлаач Д.Гүндэгмаа шалгарсан. | 100 |
| 34 | 2.5.8 | ЮНЕСКО-д бүртгэгдсэн 15 соёлын биет бус өвийг сурталчлах, үзэсгэлэн зохион байгуулахад музейг мэргэжил арга зүйгээр хангаж хамтран ажиллана. | | Зохион байгуулсан музейн тоо.<br><br>Үзэгчдийн тоо.<br><br>Хамрагдсан соёлын биет бус өвийг өвлөн уламжлагч хүний тоо. | Анх удаа | 8 хүртэлх музейн үзэсгэлэнгийн танхимд ЮНЕСКО-д бүртгэгдсэн 15 соёлын биет бус өвийн чиглэлээр олон нийтэд зориулсан үйл ажиллагааны зохион байгуулалтад хамтран оролцсон байна. | II-IV | Соёлын өвийн бүртгэл, судалгааны газар<br><br>Мэдээллийн технологи, аюулгүй байдлын газар | ЮНЕСКО-ийн соёлын биет бус өвийн жагсаалтад бүртгэгдсэн 15 соёлын биет бус өвийг сурталчлахад дараах 4 музейтэй хамтран 6 үзэсгэлэн зохион байгуулж, мэргэжил арга зүй, холбогдох гэрэл зураг, өвлөн уламжлагчийн мэдээллээр хангаж, зохион байгуулагдсан арга хэмжээнд илтгэл, танилцуулга хийлээ. Үүнд:<br>- Г.Занабазарын нэрэмжит Дүрслэх урлагийн музейд "Монгол шагайн харваа"; "Уул овоо тахих зан үйл";<br>- Монголын Театрын музейд "Монгол бий биелгээ, уламжлалт бүжгийн урлал", "Монгол Лимбэчдийн уртын дуу тоглох уламжлалт арга барил-битүү амьсгаа";<br>- Чойжин ламын сүм музей; "Монгол цуур хөгжмийн уламжлалт урлаг";<br>- Байгалийн түүхийн музей "Шувуучлахуй", "Ботго авахуулах зан үйл" өв | 100 |
| **Гурав.Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд** | | | | | | | | | | |
| Зорилт 3.1 Байгууллагын бүтэц, зохион байгуулалтыг шинэчлэн батлуулж, соёлын өвийг хамгаалах үйл ажиллагааг үндэсний хэмжээнд соёлын өвийг хамгаалах байгууллага, хуулийн этгээд, иргэнтэй хамтран зохион байгуулна.<br>(СӨХ тухай хуулийн 20.3, 26.1 дэх заалт) | | | | | | | | | | |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 35 | 3.1.1 | Байгууллагын бүтэц, дүрмийг Соёлын сайдаар шинэчлэн батлуулж, үйл ажиллагааг мөрдүүлж ажиллана. | Байгууллагын төсөв | Соёлын өвийг хамгаалах хуулийн 20.3 дахь заалтыг хэрэгжүүлсэн байдал.<br><br>Бүтэц, орон тоог оновчтой хуваарилсан байдал.<br><br>Нэмэгдсэн нэгж.<br>Нэмэгдсэн орон тоо. | 2021 оны байдлаар 5 нэгж, 35 ажилтантай. | Шинэчилсэн бүтцээр 7 хүртэлх нэгж, 65 хүртэлх орон тоогоор нэмэгдэж, соёлын өвийг бүртгэх, судлах, хадгалах, сэргээн засварлах, авран хамгаалах, сурталчлах чиглэлээр улсын хэмжээнд соёлын өвийг хамгаалах үйл ажиллагааг явуулна. | I-II | Захиргаа, удирдлагын газар | Соёлын сайдын 2022.04.28-ны өдрийн А/116 тоот тушаалаар шинэчлэгдэн батлагдсан "Соёлын өвийн үндэсний төвийн дүрэм"-д үндсэн 7 газар, орон тооны бус 4 зөвлөлтэй байхаар тусгагдсан нь Үндэсний төвийн бүтэц, зохион байгуулалтад 2 нэгж шинээр бий болж, орон тоог 35 хүртэл хүнээр нэмэгдүүлсэн. Дүрмийн шинэчлэлтийг хэрэгжүүлж:<br>- Үндэсний төвийн дэргэд орон тооны бус "Эрдмийн Зөвлөл"-ийг шинээр нэмж байгуулсан.<br>- Хуулиар хүлээсэн чиг үүргийн хэрэгжилттэй холбогдуулан 5 газрын бүтэц, зохион байгуулалтад өөрчлөлт оруулсан;<br>- "Хадгалалт хамгаалалт, технологи судалгааны газар", "Түүхэн дурсгалт барилга, архитектурын дурсгалыг хамгаалах газар" гэсэн 2 газрыг шинээр байгуулсан;<br>- Төрийн албаны тухай хуулийн 3.1.3, 3.1.4 дугаар зүйлд тус тус заасанчлан чадахүйн зарчим /мерит/-ийг баримтлан сул гарсан болон шинээр бий болсон орон тоонд хувь хүний мэдлэг, боловсрол, мэргэжил, мэргэшил, ур чадвар, туршлагад тулгуурлан салбарын музей, соёлын байгууллагын ажиллагсдаас соёлын өвийн бүртгэл, сэргээн засварлах, хадгалалт хамгаалалт, авран хамгаалах эрсдэлийн судалгаа, барилга архитектур, мэдээллийн технологи болон захиргааны чиглэлээр нийт 20 ажилтанг шинээр бий болсон албан тушаалд, 3 ажилтанг сул гарсан орон тоон дээр тус тус ажилд авсан;<br>- Бүтцийн өөрчлөлтөөр 11 ажилтанг албан тушаалд томилсон, холбогдох газар нэгжид шилжүүлсэн зэрэг бүтэц, зохион байгуулалтын дагуу ажлын байрыг оновчтой тогтоон байршуулах өөрчлөлтүүд хийгдсэн. 2022 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар тус Үндэсний төвийн үндсэн 7 газар нэгжид 58 ажилтан, албан хаагч ажиллаж байна. Бүтэц, зохион байгуулалтыг өргөтгөж хүний нөөцийг нэмэгдүүлснээр соёлын өвийн бүртгэл, сэргээн засварлалт, хадгалалт хамгаалалтын судалгаа, авран хамгаалах, сурталчлах хуулиар хүлээсэн чиг үүргийг хэрэгжүүлэх байгууллагын чадавхийг сайжруулж улмаар олон улс бүс нутгийн түвшинд хүргэх нөхцөл боломжийг бүрдүүлж байна. | 100 |
| 36 | 3.1.2 | Шинээр нэмэгдсэн ажлын байрны тодорхойлолт, Баримт бичиг нягтлан шалгах комисс, Дотоод хяналтын зөвлөл, Өмч хамгаалах зөвлөл, Аврах тусгай анги, Гамшгаас хамгаалах төлөвлөгөө зэрэг байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангаж ажиллах бүтэц, үйл ажиллагааны төлөвлөгөө, журмыг шинэчлэн баталж, мөрдүүлнэ. | Байгууллагын төсөв | Боловсруулж, баталсан баримт бичгийн нэр, тоо. | 2021 онд Үндэсний төвийн захирлын тушаалаар дотоод ажлын 4 Зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журам батлагдсан. | 65 хүртэлх ажилтны ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн баталсан байна.<br><br>Байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангаж ажиллах зорилгоор 4 хүртэлх бүтэц,<br>2 хүртэлх үйл ажиллагааны төлөвлөгөө,<br>4 хүртэлх журмыг шинэчлэн баталж, мөрдүүлсэн байна. | I-II | Бүх газар нэгжүүд | Байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангаж тус Үндэсний төвийн бүтэц, үйл ажиллагааны баримт бичгүүд болох 9 журам, 65 хүртэлх орон тооны ажилтнуудын "Ажил мэргэжлийн лавлах", "Албан тушаалын тодорхойлолт"-ыг шинэчлэн боловсруулж, Үндэсний төвийн захирлын тушаалаар батлав. Мөн дотоод ажлын 6 зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн байгуулсан. Үүнд:<br>- Хөдөлмөрийн дотоод журам (захирлын 2022.05.20-ны өдрийн А/19 тоот тушаал);<br>- Албан хэрэг хөтлөлтийн журам (захирлын 2022.06.29-ны өдрийн А/24 тоот тушаал);<br>- Захиргаа, удирдлагын газар, Бүртгэл, мэдээллийн газар, Хадгалалт, хамгаалалт технологи судалгааны газар, Сэргээн засварлах газар, Түүхэн дурсгалт барилга архитектурын дурсгалыг хамгаалах газар, Авран хамгаалах, эрсдэлийн судалгааны газар, Мэдээллийн технологийн газар зэрэг 7 газар тус бүрийн ажлын дотоод журам (захирлын 2022.11.22-ны өдрийн А/52 тоот тушаал);<br>- Соёлын өвийн үндэсний төвийн Ажил мэргэжлийн лавлах", "Албан тушаалын тодорхойлолт (захирлын 2022.06.30-ны өдрийн А/27 тоот тушаал);<br>- Өмч хамгаалах Байнгын Зөвлөлийн бүрэлдэхүүн (захирлын 2022.05.16-ны өдрийн А/17 тоот тушаал);<br>- Баримт нягтлан шалгах комиссын бүрэлдэхүүн (захирлын 2022.06.29-ны өдрийн А/25 тоот тушаал);<br>- Аврах тусгай мэргэжлийн ангийн бүрэлдэхүүн (захирлын 2022.07.04-ны өдрийн А/30 тоот тушаал);<br>- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөлийн бүрэлдэхүүн (захирлын 2022.08.22-ны өдрийн А/36 тоот тушаал);<br>- Залуучуудын хөгжлийн зөвлөл (захирлын 2022.08.26-ны өдрийн А/37 тоот тушаал);<br>- Ёс зүйн зөвлөл (захирлын 2022.09.23-ны өдрийн А/43 тоот тушаал)-ийг тус тус шинэчилэн баталж, үйл ажиллагаандаа мөрдлөг болгон хэрэгжүүлэн ажиллаж | 100 |
| 37 | 3.1.3 | Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн улсын тооллогыг мэргэжил, арга зүйгээр хангаж хамтран зохион байгуулж, тайлан дүн мэдээг улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн санд хүлээн авч хадгална. | Байгууллагын төсөв | Соёлын өвийг хамгаалах хуулийн 26.1 дэх заалтын дагуу 4 жилд 1 удаа зохион байгуулагддаг түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн улсын тооллого хэрэгжинэ.<br><br>Хамрагдсан байгууллагын тоо. | 2018-2019 онд улсын тооллогод 307 байгууллага хамрагдаж, 126,810 дэсийн 276077 ширхэг дурсгалт зүйл тоологдсон. | Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй Үндэсний, Улсын, Бүс нутгийн музей, орон нутгийг судлах танхим, сүм хийд, судалгааны байгууллага зэрэг 320 хүртэлх байгууллага хамрагдсан байна.<br><br>Улсын хэмжээнд тоон дүн нэгтгэгдэж, тайлан | I-IV | Соёлын өвийн бүртгэл, судалгааны газар<br><br>Мэдээллийн технологи, аюулгүй байдлын газар | Соёлын яамнаас түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн улсын тооллого зохион байгуулах тодорхой чиглэл ирүүлээгүй байгаа учир эхлээгүй байна. | 0 |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 38 | 3.1.4 | Байгууллагын 2022 оны үйл ажиллагаанд батлагдсан төсвийн хэрэгжилтийг ханган ажиллана. | 1395,862.50 | Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулсан байдал | 2021 онд 695,800.0 төгрөгний төсөв зарцуулсан | Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж, шилэн дансанд байршуулж, аудитын дүгнэлт гаргуулна. | I-IV | Бүх газар | 2022 онд 1,378,494.9 төгрөгийн төсөв батлагдснаас 1-11 сарын хугацаанд 936,624,498.32 төгрөгийг төсвийн хуваарийн дагуу зарцуулж, хуулийн хугацаанд төсвийн зарцуулалтын мэдээллийг Шилэн дансанд байршуулсан. Шилэн дансны шалгалтаар I улиралд 97.3%, II улиралд 98.6%, III улиралд 99.1 %-тай дүгнэгдсэн бөгөөд IV улирлын шилэн дансны шалгалт 2023 оны 1-р сард дүгнэгдэнэ.<br>III улирлын байдлаар санхүүгийн аудитын явцын шалгалт эхлээгүй байгаа бөгөөд санхүүгийн баримтуудыг үдэж хавтаслан бэлтгэл ажил хангагдсан.<br>Байгууллагын үндсэн үйл ажиллагаа чиг үүргийн хэрэгжилтийг хангаж батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулсан. | 100 |
| 39 | 3.1.5 | Төрийн болон орон нутгийн музейн камер, дохиоллын системийг шинэчлэх ажилд хамтран оролцоно. | | Музейн ашиглагдаж буй камер, дохиоллын мэдээллийг нэгтгэсэн байдал, Тендерийн бичиг баримтад оролцсон байдал.<br><br>Хамрагдсан музей, нийлүүлэгдсэн камер, төхөөрөмжийн тоо. | Анх удаа | Тоног төхөөрөмжийн судалгаа хийгдэж, музейнүүдэд тоног төхөөрөмж нийлүүлэгдсэн байна. | I-IV | Соёлын өвийн бүртгэл, судалгааны газар<br><br>Мэдээллийн технологи, аюулгүй байдлын газар | Соёлын өвийн үндэсний төвөөс 2021 онд төрийн болон орон нутгийн музейгээс хяналтын камержилт, хамгаалалтын системийн мэдээллийг цуглуулах 16 үндсэн, 60 дэд асуулга бүхий маягт боловсруулан 43 байгууллагад 1/303 тоот албан бичиг хүргүүлснээс 33 байгууллага мэдээлэл ирүүлснийг, нэгтгэн боловсруулж дүн мэдээг Соёлын яаманд хүргүүлсэн.<br>Дээрх мэдээлэл дээр тулгуурлан Соёлын яамнаас төрийн болон орон нутгийн музейн камер, дохиоллын системийг шинэчлэх, тоног төхөөрөмж нийлүүлэх ажлыг Соёлын өвийн үндэсний төвийг хамтран оролцуулахаар төлөвлөгөөнд тусгасан боловч ямар нэгэн чиглэл өгөөгүй.<br>2022 оны 4 дүгээр сард Соёлын яамнаас музейн дохиолол, теле камерын ажлын хэсгийн цахим хэлэлцүүлгийг нэг удаа зохион байгуулсан бөгөөд хэлэлцүүлэгт Авран хамгаалах, эрсдэлийн судалгааны газрын дарга Г.Анхсанаа оролцож холбогдох мэдээллийг өгсөн. | 30 |
| Зорилт 3.2 Төрийн албан хаагчийн нийгмийн баталгаа, салбарын хүний нөөцийг бэлтгэх, хангах, байгууллагын ажилтны сурч боловсрох, шагнуулах, манлайлал үзүүлэх, хөдөлмөрийн аюулгүй байдал, ажлын байрны нөхцөл орчныг хангах арга хэмжээ авна. | | | | | | | | | | |
| 40 | 3.2.1 | Соёлын өв хамгаалал, судлалын ахисан түвшний сургалтад ажилтнуудыг хамруулж, байгууллагын боловсон хүчин, хүний нөөцийн чадамжийг сайжруулна. | Байгууллагын төсөв | Ахисан түвшний сургалтад хамрагдсан ажилтны тоо.<br><br>Магистрын сургалтад хамрагдсан, төгссөн ажилтны тоо.<br><br>Докторантурын сургалтад | 2021 онд давтагдсан тоогоор 15 ажилтан мэргэшүүлэх чиглэлээр сургалтад хамрагдсан. | 2022 онд 5 хүртэлх албан хаагчдыг мэргэжил болон ажлын чиг үүргийн дагуу сургалтад хамруулж чадавхжуулна. | I-IV | Бүх газар нэгжүүд | Ажлын чиг үүргийнхээ дагуу мэргэшүүлэх чиглэлээр богино хугацааны сургалтад 27 ажилтан хамрагдаж, эрдмийн зэргээ ахиулж 9 ажилтан суралцаж байна. Үүнд:<br>- Архив, бичиг хэрэг хөтлөлтийн ахисан түвшний сургалтад 1 ажилтан;<br>- Сэргээн засварлалт, хадгалалт хамгаалалтын чиглэлээр мэргэшүүлэх сургалтад- 26 (давхардсан тоогоор) ажилтан;<br>- Магистрын сургалтад 6,<br>- Докторантурын сургалтад 3 ажилтан тус тус хамрагдаж байна.<br>Сургалтад хамрагдаж буй ажилтны ажлын цагийг зохицуулж сурах нөхцөл бололцоогоор бүрэн хангаж байна. | 100 |
| 41 | 3.2.2 | Ажилтны ажлын бүтээмж, гүйцэтгэл, ур чадварыг журмын дагуу шалгуур үзүүлэлтээр дүгнэн ур чадварын<br>нэмэгдэл, ур дүнгийн урамшуулал,<br>шагнал олгож, үнэлж, урамшуулна. | Байгууллагын төсөв | Ажилчдын ур чадварын нэмэгдлийг холбогдох хууль журмын дагуу улирал бүр дүгнэн урамшуулсан байдал.<br>Албан хаагчдын ажлын үр дүн, гүйцэтгэлийг үнэлж ажилчдад олгох үр дүнгийн урамшууллыг жилд 2 удаа олгосон байдал.<br>Онцгой сайн ажилласан ажилтан, албан хаагчдад жилийн эцэст 1 удаа мөнгөн урамшуулал олгосон байдал.<br>Соёлын салбарын цол тэмдэг болон төрийн шагналаар шагнасан байдал. | 2021 од Үр дүнгийн урамшууллыг 33 ажилтанд олгосон.<br><br>2021 онд<br>Алтан гадас одонгоор 1, Хөдөлмөрийн хүндэт тэмдгээр 3, "Соёлын тэргүүний ажилтан" цол тэмдгээр 3, ажилтан, Соёлын яамны жуух бичгээр 3 ажилтан тус тус шагнагдсан | Салбарын шагнал, цол тэмдгээр болон төрийн шагналаар шагнуулах болзол хангасан 5 хүртэлх ажилтныг шагналд тодорхойлсон байна.<br><br>65 хүртэлх ажилтанд үр дүнгийн дүнгийн урамшуулал олгоно.<br><br>10 хүртэлх ажилтанд жилийн эцэст мөнгөн урамшуулал олгосон байна. | I-IV | Захиргаа, удирдлагын газар | 2022 оны 9 дүгээр сард зохион байгуулагдсан Соёл, урлагийн ажилтны өдрийг тохиолдуулан үр бүтээлтэй ажиллаж байгаа шилдэг 2 ажилтан "Соёлын тэргүүний ажилтан" цол, тэмдгээр шагнагдсан.<br>-Үндэсний төвд ажиллаж байгаад өндөр насны тэтгэвэрт гарсан 8 ахмад, олон жил үр бүтээлтэй ажиллаж буй 50-иас дээш настай 14 ажилтан (нийт 22 хүн)-г Ардын хувьсгалын 100, 101 жилийн ойн медалиар шагнуулахаар яаманд хүргүүлсэн ба одоогоор хариу шийдвэр ирүүлээгүй байна.<br>-Жил бүрийн 12 дугаар сард тэмдэглэн өнгөрүүлдэг манай улсад орчин цагийн музей үүсч хөгжсөний ойг тохиолдуулан Монгол Улсад музейн үзмэрийг сэргээн засварлах (1988 оноос эхлэн) байгууллагын суурийг тавилцаж, хөгжүүлэх үйлсэд тууштай, үр бүтээлтэй ажиллаж байгаад өндөр насны тэтгэвэрт гарсан ууган ажилтнуудын нэг болох 1 өндөр настанг салбарын шагнал "Соёлын тэргүүний ажилтан" цол, тэмдгээр, 2 өндөр настаг төрийн одон "Хөдөлмөрийн хүндэт медаль"-иар шагнуулахаар хамт олны хурлаар хэлэлцэн шийдвэрлэж, зохих материалыг бүрдүүлэн Соёлын яаманд хүргүүлхэд бэлэн болгосон.<br>-Нийт ажилтнуудын ажлын гүйцэтгэлийг сар бүр дүгнэж, ур чадварын нэмэгдлийг 25 хүртэл хувиар тооцож, 11 дүгээр сарын байдлаар 58 ажилтанд 104,330,792.46 төгрөгийн ур чадварын нэмэгдлийг;<br>-Үндэсний төвийн захирлын 2022 оны А/19 тоот тушаалаар шинэчлэгдэн батлагдсан "Хөдөлмөрийн дотоод журам"-д үр дүнгийн урамшууллыг улирал тутамд олгох тухай нэмэлт өөрчлөлт орж, 2 дугаар улирлаас эхлэн хэрэгжүүлж эхэлсэн ба 3 дугаар улирлын байдаар 58 ажилтанд 42,353,781.4 төгрөгийн үр дүнгийн урамшууллыг тус тус олгосон байна.<br>Ажилтнуудын ажлын гүйцэтгэлийн үр дүнг жилийн эцэст дүгнэж сайн ажилласан 10 хүртэл ажилтанг мөнгөн урамшууллаар шагнахаар төлөвлөсөн. Засгийн газрын тогтоолын дагуу олгож байгаа ур чадварын болон үр дүнгийн мөнгөн урамшуулал нь ажилтнуудын мэдлэг чадварыг нэмэгдүүлэх хөшүүрэг болж ажиллах таатай нөхцөлийг бүрдүүлэхэд зэрэг нөлөө үзүүлж байна. | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 42 | 3.2.3 | Соёлын өвийг сэргээн засварлах чиглэлээр тасралтгүй үр бүтээлтэй 8 жил ажилласан ажилтанд мөнгөн урамшууллыг журмын дагуу олгоно. | Байгууллагын төсөв | Музейн тухай хуулийн 15.3 дахь заалт хэрэгжинэ.<br><br>Урамшуулалд хамрагдсан ажилтны тоо. | Анх удаа | 2022 онд 8 хүртэлх сэргээн засварлагчдад 1 жилийн цалинтай тэнцэх урамшуулал олгосон байна. | I-IV | Захиргаа, удирдлагын газар | Музейн тухай хуулийн 15.3 дахь заалтыг хэрэгжилтийн хүрээнд тус Үндэсний төвд тасралтгүй 8 жил ажилласан сэргээн засварлагчдад олгох мөнгөн урамшуулал 61,010,700.0 төгрөг байгууллагын төсөвт суусанаас Засгийн газрын 2022 оны 268 дугаар тогтоолоор батлагдсан "Музейн үзмэртэй шууд харьцах албан тушаалтанд мөнгөн урамшуулал олгох тухай журам"-ын дагуу нэр бүхий 6 сэргээн засварлагчдад нэг жилийн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн урамшуулал нийт 61,010,688 төгрөгийг олгосон.<br>Нэг жилийн тэнцэх хэмжээний мөнгөн урамшуулал нь сэргээн засварлагчдын нийгмийн баталгааг хангаж, тогтвор суурьшилтай ажилуулахад томоохон дэмжлэг болж байна. | 100 |
| 43 | 3.2.4 | Ажлын таатай орчин, нөхцөлийг бүрдүүлж, ажиллах урам зориг, эрмэлзэлийг бий болгоно. | Байгууллагын төсөв | Худалдан авсан номын тоо.<br>Компьютер, техник тоног төхөөрөмжийн тоо.<br>Биеийн тамир, хөдөлгөөнт дасгалын төхөөрөмжийн тоо. | 2021 онд байгууллага 18 ном худалдан авч номын сангийн баяжуулалт хийсэн.<br><br>30 ажилтанд шинэ ширээ, сандал, номын шүүгээгээр хангасан. | Албан хэрэгцээнд 10 хүртэлх номын баяжилтыг хийсэн байна.<br><br>10 хүртэлх компьютер, техник тоног төхөөрөмжөөр хангасан байна. | I-IV | Захиргаа, удирдлагын газар | Соёлын яамнаас ажлын албан хэрэгцээнд 29ш, Дорноговь аймгийн музей 2ш, Дундговь аймгийн музей 3ш ном тус тус нийт 34 ш ном хандиваар ирж байгууллагын номын санд ажилтнуудын албан хэрэгцээнд ашиглаж байна.<br>-ХБНГУ-ын Макс Планкийн хүрээлэнгийн МАР33 төслийн судалгааны багтай хамтран археологийн дурсгалын мэдээллийн сан үүсгэх төслийн хүрээнд I7 компьютер 1ш, 27 inch дэлгэц 2ш, өнгөт принтер 1ш, хурдан скайнер 1ш, сата хард 4тв 2ш, зөөврийн хард2тв 2ш, зөөврийн хард 1тв 1ш тус тус нийт 10 ширхэг техник тоног төхөөрөмжөөр хангаж соёлын өвийн бүртгэл баримтжуулалтад ашиглаж байна.<br>- БНТУ-ын Олон улсын хамтын ажиллагаа, зохицуулах агентлаг (ТИКА)-гийн тусламжаар "Чулуун дурсгалыг сэргээн засварлах лаборатори"-ийг байгуулж, уг лабораторид "бичил цаг уурын төхөөрөмж", төрөл бүрийн "хэмжигч багажууд", "вакумжуулж хөлдөөж хатаагч төхөөрөмж", "зөөврийн компьютер", "хэт авианы хэмжилтийн багаж", "чулууны дотоод хагарал, цуурлыг хэт авиагаар хэмжигч багаж", "хэт улаан туяаны дижитал камер", "мульти спектрийн камер дрон", "гар өргөгч", "лазер цэвэрлэгээний төхөөрөмж" зэрэг 15 төрлийн орчин үеийн багаж, тоног төхөөрөмжүүдийг хандивласан юм. "Чулуун дурсгалыг сэргээн засварлах лаборатори"-ийг байгуулснаар хадны зураг бичээс, хүн болон буган чулуун хөшөө зэрэг эртний чулуун дурсгалын хадгалалт хамгаалалтын орчныг судалгаа хийх, сэргээн засварлах бэхжүүлэх ажлын хүчин чадлыг нэмэгдүүлж, ажиллах орчин нөхцөл хангагдаж байна.<br>-Ажилтнуудын хандив санаачлагаар өргөлт, суниалтын спорт дасгалын 170 кг-ын штанг, вандан сандал, тавиур зэрэг тоног төхөөрөмжөөр байгууллагын биеийн тамир, фитнессийн өрөөг нэмж тохижуулан, ажилтнуудын чөлөөт цаг, спортын арга хэмжээнд хэрэглэж байна. | 100 |
| 44 | 3.2.5 | Сэргээн засварлах ажилд химийн бодис ашиглах, худалдан авах тусгай зөвшөөрлийг холбогдох дээд байгууллагаас авч, үйл ажиллагаандаа ашиглана. | Байгууллагын төсөв | Хөдөлмөрийн аюулгүй байдал, лаборатори, агуулахын стандарт орчин бүрдүүлсэн байдал.<br>Тусгай зөвшөөрөл авсан байдал. | Анх удаа | Химийн бодис ашиглах, худалдан авах тусгай зөвшөөрөл авч, сэргээн засварлах үйл ажиллагаанд ашигласан байна. | I-IV | Захиргаа, удирдлагын газар<br><br>Соёлын биет өвийг сэргээн засварлах газар | Сэргээн засварлах ажилд химийн бодис ашиглах тусгай зөвшөөрөл авахтай холбогдуулан Монгол Улсын Байгаль орчныг хамгаалах тухай, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай, Химийн хортой аюултай бодисын тухай, Хог хаягдлын тухай зэрэг холбогдох хууль тогтоомж, Химийн бодисын агуулах MNS 6458:2014 Монгол Улсын стандартын шаардлагуудыг ханган ажиллаж, Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас "Химийн бодис ашиглах тусгай зөвшөөрөл"-ийг 2022 оны 9 дүгээр сард авсан. Химийн бодис ашиглах тусгай зөвшөөрлийн хүрээнд:<br>- Хан-Уул дүүргийн Онцгой байдлын газраар хянуулж "Химийн ослоос урьдчилан сэргийлэх, ослын үед ажиллах төлөвлөгөө"-г батлуулсан (2022.7.07),<br>- нийслэлийн Мэргэжлийн хяналтын газраас "Химийн бодисын агуулахын дүгнэлт" гаргуулсан (2022.7.18),<br>- нийслэлийн Байгаль орчны газраар "Байгаль орчинд нөлөөлөх нөлөөллийн Ерөнхий үнэлгээ" хийлгэсэн (2022.8.03),<br>- тусгай зөвшөөрөлтэй компанитай химийн бодис нийлүүлэх, шилжүүлэх, хог хаядлыг устгалд оруулах гэрээнүүдийг байгуулсан,<br>- стандартад нийцүүлэн химийн бодис агуулах агуулах өрөөг засаж тохижуулсан,<br>- сэргээн засварлагчдыг хөдөлмөр хамгааллын хувцас, хэрэгслээр хангасан,<br>- химийн бодистой ажиллах үеийн аюулгүй ажиллагааны дотоод журмыг боловсруулсан,<br>- хадгалалт хамгаалалт, технологи судалгааны газар Ариутгалын технологич (химич) гэсэн орон тооны үндсэн ажлын байрыг бий болгосон зэрэг шат дараалсан арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж, Монгол Улсын байгаль орчин хийгээд химийн бодисийн ашиглалттай холбогдох хууль тогтоомжуудыг мөрдөж, хөдөлмөрийн эрүүл ахуй аюулгүй байдлыг ханган ажиллаж байна. | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 45 | 3.2.6 | Сэргээн засварлалтын ажилд хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах, эрүүл мэндийг хамгаалах зорилгоор сургалт зохион байгуулж, ажилчдын эрүүл мэндийг хамгаалж, урьдчилан сэргийлнэ. | Байгууллагын төсөв | Хөдөлмөрийн аюулгүй байдлын сургалт зохион байгуулсан тоо<br><br>Хамрагдсан ажилтны тоо<br><br>Ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх үүднээс амны хаалт, гар ариутгах | Хөдөлмөрийн аюулгүй байдлын сургалт анх удаа<br><br>2021 онд амны хаалт, гар ариутгалын бодис 12 удаа хангасан. | Химийн бодистой харьцах, ажиллах, хөдөлмөрийн аюулгүй ажиллах зөвлөгөөг байнга өгч тэмдэглэл хөтлүүлж хэвшсэн байна.<br><br>Хөдөлмөрийн аюулгүй байдлын сургалтыг 3 хүртэлх удаа зохион байгуулна. | I-IV | Захиргаа, удирдлагын газар<br><br>Соёлын биет өвийг сэргээн засварлах газар | Химийн бодис хадгалах, ашиглах, харьцах, хөдөлмөр хамгаалал аюулгүй байдлын сургалтыг 2 удаа зохион байгуулсан ба сургалтад 15 сэргээн засварлагч, хадгалалт хамгаалалтын 3 ажилтан хамрагдав. Сургалтаар химийн бодистой харьцах, ашиглах үед хэрэглэх багаж хэрэгслийн талаарх мэдлэг ойлголтоо дээшлүүлсэн.<br>Ажилтнуудыг химийн бодистой харьцах, хөдөө орон нутаг томилолтоор ажиллах үед хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны заавар зөвлөгөөг өгч "Хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны заавар зөвлөгөөний дэвтэр"-т тэмдэглэж байна.<br>Хөдөлмөр хамгаалал аюулгүй байдал, "Ковид-19" цар тахлаас урьдчилан сэргийлж 120.000 төгрөгийн үнэ бүхий 7 хайрцаг маск, 5 ширхэг гар ариутгах бодисоор хангасан нь хадгалалт хамгаалалт болон сэргээн засварлах газрын мэргэжилтнүүд анхан шатанд химийн бодис хэрэглэгдэхүүнээс урьдчилан сэргийлж, аюулгүй байдлыг хангаж ажиллах боломж бүрдсэн. | 100 |
| **Дөрөв. Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилтын хүрээнд** | | | | | | | | | |
| Зорилт 4.1 Соёлын өвийн чиглэлээр иргэн, хуулийн этгээдэд лавлагаа, мэдээлэл өгөх, хууль сахиулах байгууллагатай хамтран ажиллах, соёлын өвийг таньж тогтоох үйлчилгээг чанартай шуурхай үзүүлж, салбарын ажилтныг мэргэжил арга зүйгээр хангаж, авилгаас ангид, санхүүгийн сахилга баттай байж, төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг байгууллагын вэб хуудас, цахим орчинд нээлттэй мэдээлнэ.<br>(СӨХ тухай хуулийн 20.3 дахь заалт) | | | | | | | | | |
| 46 | 4.1.1 | Иргэн, хуулийн этгээдийн хүсэлтээр соёлын өвийн лавлагаа, мэдээллийг түргэн шуурхай олгож, зөвлөмжийг байгууллагын вэб хуудас, цахим орчинд байршуулна. | Байгууллагын төсөв | Хүсэлтийн тоо.<br><br>Соёлын өвийн лавлагаа, мэдээллээр хангасан иргэний тоо.<br><br>Соёлын өвийн лавлагаа, мэдээллээр хуулийн этгээдийг хангасан тоо. | 2021 онд 3 иргэн, 5 байгууллагад хүрч үйлчилсэн. | Иргэн, хуулийн этгээдийн хүсэлтийн дагуу соёлын өвийн чиглэлээр лавлагаа мэдээллийг тухай бүр өгч, төрийн үйлчилгээг хурдан шуурхай хүргэсэн байна. | I-IV | Соёлын өвийн бүртгэл, судалгааны газар | 2022 онд 64 байгууллага, 490 иргэнд мэргэжил аргазүйн зөвлөгөө, 38 байгууллага, 8 иргэнд лавлагаа мэдээлэл олгож, хариуг албан бичгээр хүргүүлэв.<br>Мэргэжил аргазүйн зөвлөгөө:<br>-Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын тооллого, бүртгэн баримтжуулалтын чиглэлээр 21 аймгийн Соёл, урлагийн газрын соёлын өв хариуцсан мэргэжилтэнүүдэд;<br>-Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн бүртгэлийн чиглэлээр Чингис хаан музей, Үндэсний төв архив, Ховд их сургууль, Дотоод хэргийн их сургууль, "Женкотур бюро" ХХК, Нисэхийн түүхийн музей, Хэнтий аймгийн музей, Хэнтий аймгийн Баян-Овоо сумын ОНСТ, Сүхбаатар аймгийн 4 сумдын ОНСТанхим нийт 11 байгууллага, 42 иргэнд;<br>-Баримтат өвийн бүртгэл, урьдчилсан жагсаалтын чиглэлээр 32 байгууллага, 446 иргэнд;<br>-Соёлын биет бус өвийн бүртгэлийн чиглэлээр 20 байгууллага, 2 иргэнд.<br>Лавлагаа, мэдээлэл:<br>-Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын бүртгэл, археологийн хайгуул, малтлага судалгааны чиглэлээр 3 иргэн, 12 хуулийн итгээдэд нийт 15 лавлагаа, мэдээлэл;<br>-Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн бүртгэл, мэдээлэл, судалгааны чиглэлээр 18 байгууллага, 2 иргэнд нийт давхардсан тоогоор 26 удаагийн лавлагаа, мэдээлэл, 3.17GB цахим файл;<br>-Соёлын биет өвийн талаарх лавлагаа, мэдээллийг 8 байгууллагад, соёлын биет бус өвийг өвлөн уламжлагч 3 иргэнд бүртгэгдсэн тухай тодорхойлолтыг тус тус албан бичгээр хүргүүлэв.<br>Нийт давхардсан тоогоор 102 байгууллага, 498 иргэнд мэргэжил аргазүйн зөвлөгөө болон соёлын өвийн мэдээлэл лавлагаа олгож, төрийн үйлчилгээг түргэн шуурхай хүргэв. Цахим үйлчилгээний нэгдсэн портал E-Mongolia-гаар дамжуулан соёлын өвийн лавлагаа, мэдээллийг олгох үйлчилгээг нэвтрүүлэхээр техник боловсруулалтыг хийж дуусган, туршиж байна. | 100 |
| 47 | 4.1.2 | Иргэн, хуулийн этгээдийн хүсэлтээр соёлын биет өвийг таньж тогтоох үйлчилгээ үзүүлж, дүгнэлт гарган, хариуг албан бичгээр хүргүүлнэ. | Байгууллагын төсөв | Хүсэлтийн тоо.<br><br>Таньж тогтоосон соёлын өвийн тоо.<br><br>Соёлын өвийн эсрэг гэмт хэрэгт холбогдсон өвийн тоо. | 2021 онд 12 иргэн, 4 байгууллагын хүсэлтээр 103 ширхэг эд зүйлийг таньж тогтоох үйлчилгээ үзүүлсэн. | Хууль, хяналтын байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн хүсэлтээр үйлчилгээ үзүүлсэн байна. | I-IV | Соёлын өвийн бүртгэл, судалгааны газар | 2022 онд иргэн, байгууллагын нийт 210 ширхэг эд зүйлийг таньж тогтоох үйлчилгээ үзүүлж, хариуг албан бичгээр хүргүүлэв. Үүнээс 4 удаагийн 108 ширхэг эд зүйлд шинжээчийн дүгнэлт, 12 иргэний 40 ширхэг эд зүйлийг тодорхойлж Соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн санд бүртгэсэн, 2 иргэний 2 ширхэг эд зүйлийг түүх, соёлын дурсгалт зүйлд хамаарахыг, 18 иргэн, аж ахуй нэгжийн 90 ширхэг эд зүйлийг түүх соёлын дурсгалт зүйлд хамаарахгүйг тус тус тодорхойлсон. Ажлын үр дүнд Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 33 дугаар зүйлийн хэрэгжилт хангагдаж, соёлын өвийн хамгаалалт сайжрахад тодорхой нэмэр оруулав. Төрийн үйлчилгээг шуурхай, хүртээмжтэй хүргэх зорилгоор цахим үйлчилгээний нэгдсэн портал E-Mongolia-гаар дамжуулан соёлын өвийг таньж тогтоох, бүртгэх тухай хүсэлтийг хүлээн авах үйлчилгээг нэвтрүүлэхээр техник боловсруулалтыг хийж дуусган, туршиж байна. | 100 |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 48 | 4.1.3 | Байгууллагын үйл ажиллагааг хэвийн явуулах зорилгоор төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээг худалдан авч, хэрэгжүүлсэн байна. | | Бараа, ажил үйлчилгээ худалдан авсан тоо.<br>Цахим хуудсанд байршуулсан байдал.<br>Байгууллагын батлагдсан төсвөөр худалдан авсан бараа, ажил үйлчилгээний тоо.<br>Нэмэлт санхүүжилтээр худалдан авсан бараа, ажил үйлчилгээний тоо. | 2021 онд нийт 2 бараа, ажил үйлчилгээ худалдан авсан.<br>2 удаа цахим хуудсанд байршуулсан.<br>Байгууллагын төсвөөр гэрээт харуул хамгаалалтын 1 ажил үйлчилгээ худалдан авсан.<br>Нэмэлтээр 1 төрлийн бараа, ажил үйлчилгээ худалдан авсан<br>5-20 сая төгрөгийн худалдан авалт 19 удаа хийсэн. | 2022 онд байгууллагын батлагдсан төсвөөр 1 ажил,<br>Хөрөнгө оруулалтаар (Төрийн худалдан авалт) 1, нийт 2 бараа, ажил үйлчилгээг хуулийн дагуу харьцуулалтын аргаар нээлттэй зарлаж, худалдан авсан байна.<br><br>Худалдан авалттай холбоотой мэдээллийг тусгай цахим хуудсанд байршуулж, тайлан мэдээг шилэн дансанд байршуулсан байна. | | I-II | Захиргаа, удирдлагын газар | Үндэсний төвийн захирлын 2022 оны А/13 тоот тушаалаар "Гэрээт харуул хамгаалалтын ажил үйлчилгээний тендер шалгаруулалт", 2022 оны А/50 дугаар тушаалаар "Соёлын баримтат өвийг сэргээн засварлахад шаардлагатай тоног төхөөрөмж нийлүүлэх тендер шалгаруулалт"-ыг зохион байгуулах Үнэлгээний хороо байгуулагдаж, худалдан авах цахим системээр дамжуулан тус 2 тендер шалгаруулалтыг зохион байгуулсан.<br>- Гэрээт харуул хамгаалалтын ажил үйлчилгээний тендер шалгаруулалтыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, тендер шалгаруулалтын онцгой журмын харьцуулалтын аргаар зохион байгуулав. Ажлын үр дүнд 36,000,000 төгрөгний төсөвт өртөгтэй, СӨҮТ/202205001 гэрээний дугаар бүхий тендер шалгаруулалтыг 2022.06.10-ны өдөр нээж, тендерт "Их шүтээн уул" ХХК шалгаран, 1 жилийн гэрээ байгуулан харуул хамгаалалтын үйлчилгээ үзүүлж байна<br>- "Соёлын баримтат өвийг сэргээн засварлахад шаардлагатай тоног төхөөрөмж нийлүүлэх тендер шалгаруулалт" 3 удаа зохион байгуулагдсан бөгөөд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, тендер шалгаруулалтын онцгой журмын харьцуулалтын аргаар зохион байгуулагдсан тус тендерийн эхний 2 удаагийн шалгаруулалтад оролцогч оролцоогүй амжилтгүй, 3 дахь удаагийн тендер шалгаруулалт амжилттай болж, хянан үзэх шатандаа явж байна.<br>Соёлын сайдын 2021 оны А/167 тоот тушаалын хэрэгжилтийг хангаж Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дүгээр зүйл, Тендер шалгаруулалтын онцгой журам 34.1.1 дэх заалт гэрээ шууд байгуулах аргаар 22,046,400 төгрөгийн үнэ бүхий 8 нэр төрлийн баримтжуулалтын, 1 ш сорогч, 1 багц вакум сорогч зэрэг тоног төхөөрөмжийг тус тус худалдан авч, баримтат өвийн сэргээн засварлахад ашиглагдаж байна. | 100 |
| 49 | 4.1.4 | Үр дүн суурилсан төсвийн шинэтгэл болон ёс зүйтэй төрийн албаны шинэтгэлийн ажлыг Соёлын яамны ТЗУГ-тай хамтарч хийнэ. | | Шинэтгэл хийхэд бэлтгэл хангасан байдал | Анх удаа | Шинэтгэл хийхэд бэлтгэл хангасан байна. | | I-IV | Захиргаа, удирдлагын газар | Төсвийн шинэтгэлийн хүрээнд Засгийн газрын 2022 оны 107 дугаар тогтоолоор албан тушаалын ТҮСУ зэрэглэлийн дагуу 20 ажилтны цалин хөлс нэмэгдсэн. Төсвийн шинэтгэл хийгдсэнээр ажилтнуудын тогтвор суурьшилтай ажиллахад зэрэгээр нөлөөлж байна.<br>Төрийн албаны хүний нөөцийн программ шинэчлэл хийсэнтэй холбогдуулан байгууллагын нийт 57 хүний нөөцийн мэдээллийг шинэ https://hrm.csc.gov.mn/ программд бүрэн оруулсан.<br>ERP программд 57 ажилтны албан тушаал, ажил мэргэжлийн ангилал, цалингийн сүлжээ шатлал зэрэг мэдээллийг бүрэн оруулж, уг системийн Албан бичиг цэсийг албан хэрэг хөтлөлтөд бүрэн ашиглаж эхэлсэн. ERP систем нэвтрүүлснээр ажлын бүтээмж, хариуцлага дээшлэх, иргэдэд хүргэх төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах боломж бүрдэж байна. | 100 |
| Зорилт 4.2 Соёлын өвийг бүртгэх, хадгалж хамгаалах чиглэлээр музей, соёлын байгууллагын ажилтнуудад төрөлжсөн мэргэжил арга зүйн зөвлөгөө бүхий сургалт зохион байгуулж, мэргэжлийн ур чадвар, чадавхыг сайжруулна. | | | | | | | | | | | |
| 50 | 4.2.1 | Музей, соёлын салбарын байгууллагын ажилтнуудад соёлын өвийн бүртгэл, судалгааны чиглэлээр сургалт зохион байгуулж, сургалтын хэрэгжилтийн үр дүнг тухайн байгууллагаас авна. | Байгууллагын төсөв | Хамрагдсан байгууллагын нэр, тоо.<br><br>Хамрагдсан ажилтны тоо.<br><br>Сургалтын нэр, төрөл. | 2021 онд 8 төрлийн сургалт зохион байгуулсан. | Нийт 3 хүртэлх цуврал сургалтыг зохион байгуулна. | | I-IV | Соёлын өвийн бүртгэл, судалгааны газар<br><br>Мэдээллийн технологи, аюулгүй байдлын газар | Тайлант хугацаанд 12 удаагийн сургалт зохион байгуулав.Үүнд:<br>- Соёлын өвийн шилжилт хөдөлгөөн, тоон дүн, мэдээллийг нэгтгэх, тайлагнахад шат шатны бүртгэл, мэдээллийн санг мэргэжил, арга зүйгээр хангах зорилго бүхий "Соёлын өвийн бүртгэл, мэдээллийн санчдын чадавхыг бэхжүүлэх нь" сургалтыг зохион байгуулав. Тус сургалтаар соёлын өвийн бүртгэл, мэдээллийн сан бүрдүүлэлт, төрөлжсөн бүртгэлийн мэдээлэл, хадгалалт хамгаалалтын үнэлгээ хийх арга зүй, соёлын өвийн бүртгэл, мэдээллийн сангийн ашиглалт, соёлын өвийн үзлэг, тооллогын явцын мэдээ, бүртгэлийн цахим программын хэрэглээний тухай мэдлэг, ойлголтыг нэмэгдүүллээ.<br>- "Соёлын өвийн бүртгэл, мэдээллийн сангийн бүрдүүлэлт, бүртгэн баримтжуулалтын арга зүй" сэдэвт сургалтыг Хэнтий аймгийн музей, Ховд аймгийн музей, Хархорум музей, Нисэхийн түүхийн музейн ажилтнуудад тус тус зохион байгуулав.<br>- Хэнтий аймгийн Соёл, урлагийн газрын хүсэлтийн дагуу тус аймагт зохион байгуулагдсан "Соёлын ажилтны сургалт, зөвлөгөөн" арга хэмжээнд оролцон "Аймаг, сумын соёлын өвийн бүртгэл, мэдээллийн сан бүрдүүлэлт" сэдэвт сургалтыг арга зүйгээр хангаж зохион байгуулав.<br>- Баримтат өвийн төрөлжсөн бүртгэл, мэдээллийн сан бүрдүүлэх аргазүйн танхимын болон цахим сургалтыг Чойжин ламын сүм музей, Дүрслэх урлагийн музей, Үндэсний түүхийн музей, Сүхбаатар, Өвөрхангай, Дорнод, Баян-Өлгий аймгийн Соёл, урлагийн газар, Соёлын төвийн ажилтнуудад зохион байгуулав.<br>Үр дүнд: Аймаг, нийслэлийн Соёл, урлагийн газрын 22 мэргэжилтэн, төрийн болон орон нутгийн өмчийн 42 музейн 88 ажилтан, 21 сумын соёлын төвийн эрхлэгч, соёлын өв хариуцсан ажилтан сургалтад хамрагдаж, мэргэжил арга зүйгээр хангагдсан байна. | 100 |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 51 | 4.2.2 | Музей, соёлын салбарын байгууллагын ажилтнуудад соёлын өвийн хадгалалт хамгаалалтын чиглэлээр чадавхи бэхжүүлэх сургалт зохион байгуулж, сургалтын хэрэгжилтийн үр дүнг тухайн байгууллагаас авна. | Байгууллагын төсөв | Хамрагдсан байгууллагын нэр, тоо.<br><br>Хамрагдсан ажилтны тоо.<br><br>Сургалтын нэр, төрөл. | 2021 онд 19 төрлийн сургалт зохион байгуулсан. | Нийт 6 хүртэлх төрөлжсөн сургалтыг зохион байгуулна. | I-IV | Соёлын биет өвийг сэргээн засварлах газар<br><br>Соёлын өвийг авран хамгаалах газар | Музей, эрдэм шинжилгээний хүрээлэн, архивын газар, их дээд сургууль зэрэг 12 байгууллагын 160 (давхардсан тоогоор) ажилтан албан хаагчдад дараах сэдвүүдээр 8 удаа сургалт зохион байгуулсан.<br>-Чойжин ламын сүм музейн ажилтнуудад "Цаасан суурьтай баримтат өвийн хадгалалт хамгаалалт, сэргээн засварлалт";<br>-БНСУ-ын Солонгос улсын Соёлын өвийн судалгааны үндэсний төвтэй хамтран "Чулуун соёлын өвийн хадгалалт хамгаалалт";<br>-Оросын Холбооны улсын автономит БНБУ-ын Өвөр байгалийн музей, Богд хааны ордон музей, Дүрслэх урлагийн музейн мэргэжилтнүүдэд "Онол практик хосолсон сургалт";<br>-Улаанбаатар музейн албан хүсэлтийн дагуу музейн сан хөмрөг үзэсгэлэнгийн танхимд хадгалалт хамгаалалтын анхан шатны зөвлөгөө өгч "Соёлын өвийн хадгалалт хамгаалалтын шинжлэх ухаан";<br>-Токио хотын хадгалалт хамгаалалтын хүрээлэнгийн мэргэжилтнүүдтэй хамтран "Музейн орчин дахь органик хүчлийн нөлөө болон түүнээс сэргийлэх аргачлалын тухай" сэдэвт цахим сургалт;<br>- Соёлын өвийн үндэсний төв, Уран зургийн галерейн ажилтнуудад "Соёлын өвийн хадгалалт хамгаалалтад хэрэглэж байгаа химийн бодис, бодистой ажиллах аюулгүй ажиллагаа";<br>- Нийслэлийн архивын газрын албан хүсэлтийн дагуу цаасан суурьтай баримтат өвийн сан хөмрөгийн хадгалалт хамгаалалт хийж буй байдалтай танилцаж анхан шатны зөвлөгөө өгч, сургалт тус тус зохион байгуулсан.<br>Сургалтаар соёлын биет өвийн хадгалалт хамгаалалтын шинжлэх ухааны олон талт суурь судалгааны аргазүйг олон улсын жишигт нийцсэн хэлбэрээр туршлага солилцож, органик болон органик бус материалын хадгалалт хамгаалалт, сэргээн засварлалт, хүрээлэн буй орчны эрсдэл, тогтвортой орчин бүрдүүлэлт зэрэг судалгааны аргазүйг онол, практик хосолсон хэлбэрээр дунд болон ахисан шатны мэдлэгийг дотоод гадаадын мэргэжилтнүүдэд хамтарсан болон бие даасан хэлбэрээр өгч соёлын биет өвийн хадгалалт хамгаалалтын шинжлэх ухааны | 100 |
| | | | 1395,862.50 | 2022 онд Соёлын өвийн үндэсний төв нь 11 зорилтын хүрээнд 51 арга хэмжээ гүйцэтгэнэ | | | | | | |
| **Тав. Нэмэлт болон он дамжин хэрэгжиж буй ажлын хүрээнд** | | | | | | | | | | |
| 52 | 5.1 | Чингис хааны музейн үзүүлэгт дэглэх соёлын өвийн сэргээн засварлалт. | | Сэргээн засварласан хөдлөх дурсгалт зүйлийн төрөл, тоон дүн. | Анх удаа | үзмэр, эд өлгийн зүйл бүрэн сэргээн засварлагдаж үзүүлэгт дэглэх боломжийг бүрдүүлсэн байна. | II-IV | Соёлын биет өвийг сэргээн засварлах газар | Чингис хаан музейд 4959 ш үзмэрийг сэргээн засварлаж хүлээлгэн өгсөн. Үүнд:<br>-Төмөр эдлэл 2433 ш, мөнгө 1854 ш, алт, алтаар бүрсэн 175 ш, хүрэл эдлэл 264 ш, органик 46 ш, шавар 77 ш, чулуун эдлэл 15 ш, яс 14 ш, гууль 28 ш нийт 4906 ш олдворт хадгалалт хамгаалалтын болон сэргээн засварлалтын ажлыг гүйцэтгэж, тайланг бүрэн бичиж хүлээлгэн өгсөн.<br>-Үндэсний төвд хадгалагдаж байсан Ховд аймгийн Мөнххайран сумын Борт багийн нутаг "Үзүүр гяланг"-аас олдсон 41 ширхэг олдвор, 12 ширхэг чулуун дурсгалыг сэргээн засварлаж нийт 53 ширхэг үзмэр, эд өлгийн зүйлсийг тус музейд хүлээлгэн өгөв.<br>-"Чингис хаан" музейн үзмэрт зориулж орон нутгийн музейгээс үзмэр татан авах ажлын хүрээнд тус төвийн Сэргээн засварлах газрын мэргэжилтнүүд сав, баглаа боодол, аюулгүй тээвэрлэлт хийх зөвлөмжийг боловсруулан Дорноговь аймаг, Өвөрхангай аймгийн Хархорин сумын музейд ажиллав.<br>Сэргээн засварлалт хийгдэснээр музейн үзмэрийн тоо нэмэгдэж, олон нийтэд дэглэн үзүүлэх, түүхийн баримтад өвийг олон нийтэд таниулах боломжийг бүрдүүлсэн ба үзмэрийн хадгалалт хамгаалалт, сэргээн засварлалт хийх үйл ажиллагааг багаар хамтран ажиллаж зохион байгуулах аргазүйг нарийвчилсан байдлаар зохион байгуулах туршлагатай болсон. | 100 |
| 53 | 5.2 | СӨУНБМСангийн дуу дүрс бичлэгийн бүртгэлийн нэгдсэн систем бий болгох | байгууллагын төсөв | Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 25.1 дэх заалт хэрэгжинэ.<br><br>Хамрагдсан соёлын биет бус өв, өвлөн уламжлагчийн тоо.<br><br>УНБМСанд соёлын биет бус өвийн бүртгэлийн төрөлжсөн систем бий болох. | Анх удаа | Соёлын биет бус өвийн бүртгэл, мэдээлэлд техник ажиллагаа хийгдсэн байна.<br><br>Соёлын өвийн УНБМСанд төрөлжсөн товьёг үүссэн байна. | I-IV | Соёлын өвийн бүртгэл, судалгааны газар<br><br>Мэдээлэл технологийн газар | "Соёлын биет бус өвийн дуу, дүрс бичлэгийн студи"-ийг 2022 оны 2 дугаар улирлаас шинээр ашиглалтад оруулаа. Тус студи байрлах өрөөг тохижуулж, Betacam, UVW, DV, SVHS хальсыг дижитал хэлбэрт хөрвүүлэхэд шаардлагатай дуу, дүрс бичлэгийн тоног төхөөрөмж худалдан авч, суурилуулав. Тайлант хугацаанд DV хэлбэртэй 60 минутын 280 ширхэг хальсыг дижитад хувилбарт шилжүүлж, 280 цагийн, 2.81 ТВ багтаамжтай цахим файлыг түүний агуулга бүхий 370 хуудас бичвэрийг СӨУНБМСанд товьёгжуулж хадгалаад байна. Студи ашиглалтад орсноор СӨУНБМСанд хадгалагдаж байгаа Betacam, UVW, DV, SVHS хальсны бичлэг дижитал хэлбэрт хөрвүүлэгдэн Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 24.3 дахь заалт хэрэгжиж, Соёлын биет бус өв, өвлөн уламжлагчийн өвөлсөн ардын дуу, бий биелгээ, морин хуурын татлага, домог хууч яриа, зан үйлийн олон төрөл зүйлийн дахин давтагдашгүй дүрс бичлэг, баримтыг устах эрсдэлээс хамгаалах, өвийг судалгааны эргэлтэд оруулах, контент бүтээх, цахим сан үүсгэх, судлах, сурталчлах, Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэх боломж бүрдэж байна. | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 54 | 5.3 | Түүхэн дурсгалт барилга, архитектурын дурсгалын хувийн хэрэг, хөтлөх зааврыг холбогдох байгууллагуудад хүргүүлж, үр дүнг нэгтгэх | Байгууллагын төсөв | Боловсруулсан маягт, танилцуулга, заавар, тушаал.<br><br>-Хамрагдсан түүхэн дурсгалт барилга, архитектурын дурсгалын тоо. | УНБМСанд хадгалсан байдал. | Түүхэн дурсгалт барилга, архитектурын дурсгалын хувийн хэргийг хөтөлж, үр дүнг нэгтгэсэн байна. | I-IV | Соёлын өвийг авран хамгаалах газар | Үндэсний төвийн захирлын 2022 оны 5 дугаар сарын 09-ний өдрийн А/15 дугаар тушаалаар батлагдсан "Түүхэн дурсгалт барилга, архитектурын дурсгалын хувийн хэргийн маягт"-хөтлөх зааврыг аймаг, нийслэлийн Соёл, урлагийн газруудад албан бичгээр хүргүүлж, хариу ирүүлсний дагуу Соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн сангийн Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын RICH 3.0 программд түүхэн дурсгалт барилга, архитектурын дурсгалын төрөлд 1121 дурсгалт газрын 2915 дурсгал бүртгэгдсэнээс шороон туурь, үлдэгдэл, суваг, шуудуу зэрэг төрлийг хамруулалгүй орхиж, Эртний хотын туурь, Сүм хийд, туурь, Түүхэн дурсгалт байшин, Суврага гэсэн зүйлд хамаатах 676 дурсгалт газрын товч мэдээллийг нэгтгэв. Үүнээс "Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалт"-д 57 дурсгалт газар, "Аймаг, нийслэлийн хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалт"-д 88 дурсгалт газар, "Дүүргийн хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалт"-д 30 дурсгалт газар, Нийт 175 дурсгалт газрыг тус тус хамгаалалтын зэрэглэлд хамруулсан байна. Хамгаалалтын зэрэглэл бүхий 175 дурсгалыг төрөл зүйлээр нь ангилахад эртний хотын туурь-60, түүхэн дурсгалт байшин-54, сүм хийд, туурь-51, суврага-10 байна. Дурсгалын ашиглалтын байдлыг нэгтгэхэд ашиглалтай-67, ашиглалтгүй-106 дурсгал, ашиглалтын байдал тодорхойгүй-2 дурсгал байна. Хамгаалалтын зэрэглэл бүхий 175 дурсгалын хадгалалт, хамгаалалтыг сайжруулах зорилгоор Соёлын яамны төлөвлөлтөд хамрагдсан, аялал жуулчлалын бүс нутагт байрлаж байгаа, эвдрэл гэмтэл нь шууд ил харагдаж байгаа зэрэг мэдээлэлд түшиглэн төлөвлөлтийг:<br>- Хүчитгэх, бэхжүүлэх шаардлагатай-47<br>- Сэргээн засварлах шаардлагатай-56<br>- Сэргээн засварлах шаардлагагүй-72 хэмээн ангилж, холбогдох дурсгалыг төлөвлөлтийн дагуу нэгтгэв. Түүхэн дурсгалт барилга, архитектурын дурсгалын хувийн хэргийн маягт"-аар түүхэн дурсгалт барилга, архитектурын дурсгалын ашиглалтын байдалд судалгаа, хяналт хийхэд чухал ач холбогдолтой. | 100 |
| 55 | 5.4 | Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын улсын тооллого зохион байгуулахад хамтран оролцох. | Соёлын яамны санхүүжилт | Тооллого хийгдсэн аймаг, нийслэлийн тоо.<br>Тооллогод хамрагдсан үл хөдлөх дурсгалын тоон дүн. | 2015 онд нийт 9537 дурсгалт газрын 86157 дурсгал бүртгэгдсэн. | Улаанбаатар хот, 21 аймгийг хамруулах.<br>Улс, аймаг, нийслэлийн хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг бүрэн хамруулах.<br>Өмнөх 2015 оны улсын тооллогод хамрагдсан нийт дурсгалыг хамруулах. | II-IV | Соёлын өвийн бүртгэл, судалгааны газар,<br><br>Мэдээллийн технологи, аюулгүй байдлын газар,<br><br>Соёлын өвийг авран хамгаалах газар. | ЗГХА Соёл, урлагийн газрын даргын 2022 оны А/10, А/14 дугаар тушаалын дагуу "Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын улсын тооллого-2022"-ыг зохион байгууллаа.<br>Тооллогын бэлтгэл ажлын хүрээнд:<br>- Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын улсын тооллогын удирдамж, төлөвлөгөө, хадгалалт хамгаалалтын маягтыг боловсруулж батлуулсан;<br>- Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын www.rich.mongoluv.mn бүртгэлийн цахим программ ашиглалтад оруулсан;<br>- "Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын тооллого-2022" мэргэжил аргазүйн нэгдсэн сургалт улсын хэмжээнд зохион байгуулсан;<br>- "Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын тооллого-2022" гарын авлага боловсруулан хэвлүүлж, 21 аймгийн 330 сум, нийслэлийн 9 дүүрэгт хүргүүлсэн;<br>- "Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын тооллого-2022" тооллогын дэвтрийг хэвлүүлж аймаг, нийслэлийн Салбар комисст хүлээлгэн өгсөн.<br>Тооллогын үйл явц, үр дүн:<br>- Улсын комиссоос Салбар комисст чиглэл, арга зүйн зөвлөгөө өгөх, программд мэдээлэл оруулах, тайлан бичих заавар зөвлөгөөг нийт 6 удаагийн цахим хурал, сургалтаар өгсөн;<br>-Тооллогын явцын мэдээллийг Соёлын өвийн үндэсний төвийн вэб хуудас, сошиал сувгуудаар тухай бүр дамжуулан хүргэсэн;<br>- Тооллогын хээрийн судалгаа улсын хэмжээнд 2022 оны 8 дугаар сараас эхлэн 11 дүгээр 20-ны өдрийн байдлаар бүрэн дууссан;<br>- Улсын хэмжээнд нийт 9266 дурсгалт газар тооллогод хамрагдахаас 2022 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар 9137 дурсгалт газар буюу 98.6%-ийн мэдээлэл программд бүрэн ороод байна. Тооллогын тайланг аймаг, нийслэлээс хүлээн авч нэгтгэх ажил явагдаж байна;<br>- Үр дүнд Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 26.1 дэх заалт хэрэгжиж, Монгол Улсын нутаг дэвсгэр орших түүх, соёлын үл хөдлөх дурсгалын нэмэлт хөгжүүлэлт хийгдсэн программ ашиглалтад орж, хадгалалт, хамгаалалтын нөхцөл байдлын нэгдсэн үнэлгээг улсын болон орон нутгийн хэмжээнд нэгтгэх, дурсгалын төрөл тус | 100 |